

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-38

<i>1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	5-8
<i>2.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	8-13
<i>3.Эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээлэл сонсох</i>	13-38

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 16-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 00 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Батсүмбэрэл, Ш.Булгантуяа, Ш.Бямбасүрэн, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, М.Мандхай, А.Ундраа, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Л.Энх-Амгалан, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар.

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Надингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа уг асуудлаар 5 өдрийн завсарлага өгөв./16:14/

Завсарлага авахтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Хоёр.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан танилцуулав.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаас Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа уг асуудлаар 5 өдрийн завсарлага өгөв./16:21/

Гурав.Эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны газрын дарга С.Цэрэнжамц, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э.Түвшинчулуун, мөн хорооны Үнэ тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хариуцлагатай хувьцаат компаний гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа, “ДЦС-3” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Сундуйжав, “Улаанбаатар дулааны сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл, референт Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Эрчим хүчний сайд Б.Найдалаа танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хуралдаанд оролцож, асуулт асууж, үг хэлж, холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгөв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Г.Очирбат, С.Бямбацогт, Л.Соронзонболд, Г.Лувсанжамц, П.Батчимэг нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны газрын дарга С.Цэрэнжамц, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э.Түвшинчулуун, “Диспетчерийн үндэсний төв” Төрийн өмчит хариуцлагатай хувьцаат компаний гүйцэтгэх захирал

Ч.Амарсанаа, “ДЦС-3” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал
Б.Сундуйжав, “Улаанбаатар дулааны сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн
гүйцэтгэх захирал Ц.Амарсанаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдлын талаарх
Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 48 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн
ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 17 цаг 48 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхимд 14 цаг 00 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Чинбаатарын Анар, Хүрэлбаатарын Булгантуяа, Жаргалсайханы Золжаргал, Баатаржавын Мөнхсоёл, Бадамдоржийн Пунсалмаа, Болдын Уянга, Отгоншарын Батнайрамдал, Болдын Жавхлан, Ганзоригийн Лувсанжамц, Эрдэнэбилигийн Одбаяр, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Пүрэвийн Батчимэг, Батбаярын Жаргалан, Загджавын Мэндсайхан, Ганбатын Очирбат, Ренчинбямбын Сэддорж, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гэсэн гишүүд ирсэн байна аа. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56.3 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 6 сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоом тогтоолын төслүүд анхны хэлэлцүүлэг хийгдэнэ.

2.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

3.Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх эрчим хүчний сайдын мэдээллийг сонсоно оо.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байгаа юу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье ээ.

Төслийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг энэ чинь би өөрөө танилцуулах юм байна тийм үү?

Санал, дүгнэлтийг танилцуулъя.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 529 дүгээр захирамжаар Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг

сайжруулах тухай хуулийн төсөл төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл мөн 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг нийт 29 гишүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа миний бие ажиллаж, ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байна аа.

Ажлын хэсэг хуулийн төслийг хэлэлцэж зарчмын зөрүүтэй саналын томьёолол 62, хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаарх 8 санал, төслийн бүтэц нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх 4 саналын томьёоллыг хэлэлцэн дэмжиж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд ажлын хэсэг нийт 6 удаа, ажлын хэсэгт дэмжих дэмжлэг үзүүлэх баг нийт 6 удаа хуралдаж, нийт 2 удаагийн хэлэлцүүлгийг төрийн байгууллагын төлөөлөл төрийн болон орон нутгийн өмчит ААН-ийн төлөөлөл, ажлын хэсгийн гишүүд, иргэд, Төрийн бус байгууллага, АХБ-ны олон улсын зөвлөхүүд, ЕСБХБ-ны төлөөллийг оролцуулан зохион байгуулж ажлын хэсэгт ирүүлсэн асуулга, санал шүүмж болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн холбогдох саналын хүрээнд ажиллаж дараах өөрчлөлтийг тусгалаа.

Хуулийн төслийн нэрийг төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай болгон өөрчлөх, Төрийн болон орон нутгийн өмчит компанийг хувийн эзэмшлээр нь 100 хувь төрийн болон орон нутгийн өмчийн компани 50 хувиас дээш төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани, 3-ны 1-ээс дээш 50 хувь хүртэл бол төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани гэж ангилах. Мөн компанийг зорилго үйл ажиллагааны чиглэлээр арилжааны болон нийтийн үйлчилгээний гэж ангилах. Энэ талаар Компанийн дүрэмд тусгах, ТӨК-ийг нийтийн үйлчилгээний үүрэг хэрэгжүүлэх Байгалийн баялгийг үндэсний эдийн засгийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах зүй ёсны монопол үйл ажиллагаа эрхлэх батлан хамгаалах болон хууль сахиулах үйл ажиллагааг дэмжих, харилцаа холбоо, банк, санхүүгийн салбарт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үүсгэн байгуулах.

Орон нутаг нь зөвхөн хуульд заасан нийтийн үйлчилгээний чиг үүргээ хэрэгжүүлж төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялаг ашиглах үндэслэлээр орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулахдаа Улсын Их Хурлын зөвшөөрөл авах.

Төрийн болон орон нутгийн өмчит компани нь зах зээлд шударга өрсөлдөх зарчмыг баримталж хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, төрийн баталгаа, хөнгөлөлттэй зээл, газар болон дэд бүтцийг зах зээлийн үнээс доогуур ашиглах худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэх, дампуурлын нийтлэг журмаас чөлөөлөгдөхгүй байх зэрэг зарчмын тайлбарыг шинээр тусгах, алтан хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан буюу хугацааг багасгасан дүрмийн өөрчлөлт оруулах. Хяналтын багцтай дүйцэхүйц хувьцаа нэмж гаргах болон дүрэмд заасан бусад шийдвэрт хориг тавих эрхтэй байх.

Хориг тавихдаа үйлчлэл хамрах хүрээг заах. Хориг тавихдаа зорилгодоо нийцсэн хамгийн бага хязгаарлалт тогтоох зарчмыг баримтлах. Төрийн болон орон

нутгийн өмчийн компани мөн тэдгээрийн өмч давамгайлсан компани зээл авах, өрийн хэрэгсэл гаргах, баталгаа гаргуулах, санхүүгийн түрээс болон түүнтэй адилтгах үүрэг хүлээхийн өмнө өрийн тогтвортой байдлын дүгнэлтийг хараат бус мэргэжлийн этгээдээр гаргуулах, компани бусад этгээдэд өрийн баталгаа гаргахыг хориглох. Ноогдол ашгийн бодлогын хувьд арилжааны зорилготой ТӨК цэвэр ашигтай ажилласан бол ноогдол ашиг хуваарилах үүрэгтэй байх. Ноогдол ашгийн зорилтот доод хэмжээг цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байхаар баримтлах. Уг хэмжээг компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээг харгалзан бууруулж болох, нийтийн үйлчилгээний компанид санхүүжилт, нөхөн төлбөр, татаас тарифын зохицуулалтыг ноогдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх, ТУЗ-ийн гишүүний тоог арилжааны зорилготой компанийн 5-аас 9 хүртэл, нийтийн үйлчилгээний компани 5-аас илүүгүй сондгой тоотойгоор тус тус тогтоох, Гишүүдийн олонхыг нь хараат бус гишүүдээс бүрдүүлэх. Түүнчлэн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс ТУЗ-ийн гишүүнд шууд чиглэл удирдамж өгөхийг хориглох. Гүйцэтгэх захирал гэх ойлголтыг гүйцэтгэх удирдлага болгон өөрчилж, удирдлагын багийн зарчмыг тусгах, гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний хугацааг нэг жил байсныг 3 жил хүртэл болгох.

Гүйцэтгэлийн үнэлгээнд санхүүгийн үр дүнгээс гадна нийтийн үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглэгчийн сэтгэл ханамж, хүний нөөцийн бодлого, эрсдэлийн удирдлага, ил тод байдлыг хамруулах.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцааг нэмэлт хувьцаа гаргах төрийн эзэмшлийн хувьцааг худалдах давхар бүртгэл хийх хэлбэрээр үнэт цаасны зах зээлд санал болгох, стратегийн чиглэлийн компанийн хувьд Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулж, зөвшөөрөл авах.

Хувьцаа санал болгох үйл ажиллагааг компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, засаглал, ил тод байдлыг сайжруулах төрийн өмчийн оролцоог оновчтой болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үндэсний болон мэргэжлийн хөрөнгө хөрөнгө оруулагчийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх, хувьцааг хаалттай захиалга, дотоодын нээлттэй захиалга, олон улсын давхар бүртгэлийн хэлбэрээр дангаар нь эсвэл хослуулан санал болгох боломжийг бүрдүүлж төрийн эзэмшлийн доод хэмжээ, саналын эрх, алтан хувьцаа, мэргэжлийн болон ГХО-ийн оролцооны нөхцөлийг тухайн компанийн онцлогт нийцүүлэн шийдвэрлэх. Тухайн компанийн ажилтныг бүтээмжтэй, ур чадвартай, тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс урамшууллын зорилгоор давуу эрхийн хувьцаа хувьцаа нь олгох боломжийг бий болгох.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн нөөц сангийн хөрөнгийг үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх технологийн шинэчлэл хийх, давагдашгүй хүчин зүйл болон зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн эрсдэлийг бууруулахад зарцуулах.

Хуулийг 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх бөгөөд хэрэгжилтийг үе шаттай хангах хүрээнд ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон орон нутгийн өмчит компанийн зохион байгуулалтыг 2028 он хүртэл хуульд нийцүүлэх шилжилтийн зохицуулалт тусгах зэрэг болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Сүхээгийн Тэнгис Монгол Улсын Ерөнхий сайдын засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх, Сарангэрэлийн Батбаяр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш доктор, Нацагдоржийн Ганболд ТӨБЗГ-ын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Аминдаваагийн Молор ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Бат-Эрднийн Төрбат ЗГХЭГ-ын ахлах референт, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч, Очирсайханы Баярмагнай Эрдэнэс Монгол компанийн Ерөнхий аудитор.

Ажлын хэсгийг танилцуулж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг баримтлан хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн. Хэлэлцүүлгийн явцад 39 дүгээр зүйлийн 39.11 дэх хэсэгт заасны дагуу гишүүд тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асуух боломжтой.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд гишүүдэд тараагдсан байх ёстой. Ажлын хэсгийн гишүүд Байнгын хорооныхон тараагдаагүй байгаа юм биш үү?

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе гишүүд ээ.

Жаргалан гишүүн горимын санал гаргая.

Б.Жаргалан: Энэ болон орон нутгийн өмчит компанийн тухай хуультай холбоотой асуудал дээр Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг бүлэг дотроо саналаа нэгтгэж энэ хууль дээр нэгдсэн байр суурьтай оролцох хүсэлтэй байгаад байгаа учраас ажлын 5 хоногийн завсарлага хүсэж байна аа.

Тэмүүжин гишүүнд үг өгье. Тэмүүжин дарга үг хэлье.

Х.Тэмүүжин: АН-ын бүлгээс энэ завсарлагатай холбоотой асуудал дээр нэг түүх сануулахгүй бол болохгүй юм шиг байна.

Анх энэ парламент хуралдаад Улсын Их Хурал ажиллаж байхад завсарлагыг хугацаагүй авдаг байсан юм. Ямар ч хугацаагүй. Тэгээд АН олонх байхдаа 2012 онд завсарлагыг хугацаатай болгох нь зохимжтой юм байна гээд хугацаатай болгоод. Гэхдээ бүлэг завсарлага авахдаа 5 хүртэл хоногийн дотор өөрөө хугацаагаа сонгодог. Энэ өөрөө цөөнхийн хэрэг учраас тэр хугацаагаар нь завсарлага өгдөг тийм хууль батлагдсан юм. Тийм учраас бүлэг 5 хоногийн завсарлага авч байна. Наана нь ажлын хэсэг хоорондоо ярилцана биз. Үл ойлгогдох санал нийлээгүй нэлээн олон юмнууд байгаа юм шиг байна лээ. Тэгээд тэр асуудлаа ярилцаад

шийдчих юм завсарлагын хугацааны наана бүлэг завсарлагаа зогсоож болно. Тэгээд 5 хоногийн хугацаатай завсарлага.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг үндэслэн АН-ын бүлгийн хүсэлтийн дагуу 5 хоногийн завсарлага өглөө.

16.14 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 2.

Хоёр.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх хэсгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан танилцуулна.

Б.Жаргалан: Эрхэм Эдийн засгийн байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх, эрх чөлөөний үзэл санааг бодит амьдралд хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг та бүхэнд танилцуулж байна аа.

Энэхүү хууль нь иргэн ААН-ийн эдийн засгийн суурь эрхийг бодитоор хамгаалж эдийн засаг дахь төрийн оролцооны зорилго хэлбэр хүрээ хязгаарыг тодорхой болгох эрх зүйн суурийг бүрдүүлэхэд чиглэж байгаа юм. Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа баталснаас хойш 36 жилийн хугацаанд зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлж хувийн хэвшилд тулгуурласан хөгжлийн загварыг бий болгохыг зорьж ирсэн. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засаг өсөж, нэг хүнд ноогдох орлого нэмэгдэж шинэ бизнесүүд бий болсон. Гэвч өсөлтийн хурд хүртээмж хангалтгүй байна. Эдийн засгийн өсөлт үнэхээр иргэн бүрийн боломжийг тэлж бизнес эрхлэх эрх чөлөөг баталгаажуулж чадаж байна уу? Манай эдийн засгийн өсөлт уул уурхайн салбарт хэт төвлөрсөн хэвээр байна. Уул уурхайн экспортын орлого нэмэгдэхийн хэрээр бусад салбарын өрсөлдөх чадвар сулрах, төрийн зардал тэлэх, бүтээмжээс илүү түүхий эдийн мөчлөгөөс хамаарах үзэгдэл хүчтэй болсон. Эдийн засгийн уналт үнэ үүнийг Голланд өвчин гэж нэрлэдэг. Энэхүү нөхцөл байдлаас гарахын тулд эдийн засгаа төрөлжүүлэх хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг сэргээх, иргэдийн бүтээлч санаачилгыг хамгаалах хөгжлийн бодлого зайлшгүй шаардлагатай байна аа.

Тиймээс бид Үндсэн хуульд тунхагласан эдийн засгийн эрх, эрх чөлөөг бодит хамгаалалттай болгож төрийн оролцооны хүрээ хязгаарыг тодорхойлох эрх зүйн шинэ суурийг бий болгохыг зорьсон. Монгол Улсын Үндсэн хууль, эдийн засгийн тогтолцооны суурийг аль хэдийн тогтоосон байдаг.

Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт хувийн өмчид тулгуурласан олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэж тодорхой заасан. Мөн 16 дугаар зүйлээр иргэн өмчтэй байх, аж ахуй эрхлэх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох хөдөлмөрийн үр шимээ хүртэх эрхийг баталгаажуулсан. Гэвч Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд бодит байдал дээр олон сорилт тулгарч байна.

Нэгдүгээрт, эдийн засаг дахь төрийн оролцоо тасралтгүй өсөж байна. Төр зөвхөн зохицуулагч биш зах зээлийн оролцогч болсон.

Хоёрдугаарт, эрх зүйн орчинг урьдчилан таамаглах боломжгүй, тогтворгүй хэвээр байна.

Гуравдугаарт дотоод ГХО-дын итгэл сул хэвээр байна.

Дөрөвдүгээрт бизнесийн зохицуулалтын зардал маш өндөр байна аа. Тухайлбал төсвийн зардал ДНБ-ий 35 хувьд хүрсэн, ТӨК-удын эдийн засаг дахь оролцоо мөн өргөжсөн. 2025 онд ТӨК-уд 25.3 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олсон нь ДНБ-ий 28 хувьтай тэнцэж байна. Ингэснээр хувийн хэвшлийн орон зай улам хумигдаж байна. Уул уурхайн орлогын өсөлтийг дагаад төсвийн хэмжээ тэлж төрийн өмчит ААН-үүдийн эдийн засаг дахь оролцоо нэмэгдсэн атлаа боловсруулах үйлдвэр өндөр бүтээмжтэй шинэ салбаруудын хөгжил харьцангуй удааширч байна. Ийм нөхцөлд төр хувийн хэвшлийн тэнцвэрийг сэргээх нь чухал юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийг төр авч явах уу, эсвэл иргэдийн санаачилга, хувийн хэвшлийн бүтээмж авч явах уу гэдэг дээр нэг мөр эрс шийдэмгий сонголт хийх нэн хариуцлагатай цаг мөч иржээ. Олон улсын судалгаанууд мөн иж ижил дүгнэлт хийж байна.

АНУ-ын Хердеж фаундэйшний 2025 оны эдийн засгийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 62.6 оноо авч 184 орноос 74 дүгээрт эрэмбэлэгдсэн. Өмчийн эрхийн хамгаалалт, эрх зүйн орчны чанар, төрийн зохицуулалтын үр нөлөө зэрэг үзүүлэлтүүд харьцангуй сул үйлдэгдэж байна. 2016 оноос хойших 10 жилийн хугацаанд Монгол Улс дунд зэргийн эрх чөлөөтэй анги ялаас гарч чадаагүй, Эдийн засгийн эрх чөлөөний институцийн чанарын ахиц хязгаарлагдмал хэвээр байна. Энэ нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг хязгаарлаж буй хүчин зүйлсийн нэг болсон.

Бизнесийн орчны олон улсын харьцуулсан үзүүлэлтүүдээс харахад Монгол Улс хөрш болон өрсөлдөгч орнуудаас хоцрох хандлагатай байна. Дэлхийн банкнаас гаргадаг байсан бизнес индекст манай улс 190 улс орноос 81-д орсон байдаг. Дотоод, гадаадын бизнес, орчны үнэлгээний бусад судалгаанууд ч тэр Монгол Улсын бизнесийн орчин хүнд суртал ихтэй зохицуулалт өндөртэйд тооцогдож байна. Энэ нь хөрөнгө оруулалт татах чадвар бизнес эрхлэх таатай орчин, эдийн засгийн тогтвортой өсөлтөд шууд нөлөөлж байна аа.

Өөрөөр хэлбэл Монгол Улс эдийн засгийн эрх чөлөөний суурь зарчмуудыг Үндсэн хуульдаа тунхагласан боловч тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн баталгаа хангалтгүй байна. Эдийн засгийн эрхийг ямар нөхцөлд хязгаарлаж болох төр ямар зарчим баримтлах, иргэн бизнес эрхээ хэрхэн хамгаалуулах талаар нэгдсэн зохицуулалт өнөөдөр байхгүй байна.

Тиймээс энэхүү хуулийн төслийг санаачилсан. Энэ хуулийн зорилго бол үндсэн хуулийн үзэл санааг бодит амьдралд хэрэгжүүлэх, эдийн засгийн эрх, эрх

чөлөөг хамгаалах, түүнийг хязгаарлах шалгуурыг тодорхой тогтоох, эдийн засгийн харилцаанд тогтвортой урьдчилан таамаглах боломжтой эрх зүйн орчин бүрдүүлэхэд оршино оо.

Хамгийн чухал нь энэхүү хууль батлагдсанаар Монгол Улс иргэн төвтэй хувийн санаачилгыг дэмжсэн хөгжлийн загварыг сонгож буйгаа тодорхой илэрхийлж баялаг бүтээгчдийн эрх чөлөө, бүтээлч санаа санаачилга, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн үр шим нь эдийн засгийн өсөлтийн жинхэнэ эх үүсвэр мөн гэдгийг төрийн бодлогын түвшинд тунхаглах болно оо.

Хуулийн төсөл эдийн засгийн эрх чөлөөг дараах агуулгаар тодорхойлж байна. Үүнд өмчийн халдашгүй байдал, хөдөлмөр, хөрөнгө оруулалтын үр шимийг хүртэх эрх, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх, санхүүгийн эрх чөлөө, мэдээллийн халдашгүй байдал, шударга өрсөлдөөн зэрэг багтана.

Эдгээр нь төрөөс олгодог боломж биш юм аа. Харин иргэдийн суурь эрх мөн.

Нэгдүгээрт, өмчийн халдашгүй байдал, хуулийн төсөлд өмчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлнэ ээ. Хувийн өмчийг зөвхөн нийтийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн зах зээлийн бодит үнэлгээнд тулгуурласан нөхөн төлбөрийг бүрэн олгосны үндсэн дээр дайчлан авах зарчмыг тогтоож байна. Мөн өмчлөгчийн эрхийг баталгаажуулах эрх зүйн орчныг сайжруулна.

2.Татвар тогтоох зарчим.

Иргэн ААН-ээс хуульд заагаагүй төлбөр хураамж шаардахыг хориглоно. Татварын тогтолцоо нь ил тод хуульд үндэслэсэн байх зарчмыг баталгаажуулна аа. Төрийн өмчит этгээдэд хуульд заагаагүй давуу байдал бий болгохгүй.

3.Гэрээний эрх чөлөө, хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаа нь гэрээнд итгэх итгэл дээр тогтдог. Төрийн үүрэг бол гэрээ байгуулахыг заах бус харин байгуулсан гэрээний хэрэгжилтийг хамгаалах явдал юм. Ингэснээр хөрөнгө оруулалтын эрсдэл буурна.

4.Аж ахуй эрхлэх эрх.

Энэхүү хуулийн төслөөр хориглоогүй бол зөвшөөрнө гэсэн зарчмыг хуульчилж байна. Зөвшөөрлийн тогтолцоо нь хамгийн бага хязгаарлалттай байх түр хуульд заасан хугацаанд шийдвэр гаргах, шаардлагагүй бичиг баримт шаардахгүй байх хууль заагаагүй шалгалт хийхгүй байх зарчмыг тогтоож байна.

5.Шугаарт шударга өрсөлдөөн.

Төрийн үүрэг бол ялагчийг сонгох явдал биш. Харин оролцогч бүр ижил дүрмээр өрсөлдөх орчныг бүрдүүлэх явдал юм. Төр ялгаварлан зохицуулахгүй, төр зах зээлд давуу оролцохгүй, төрийн худалдан авалт ил тод байж эдийн засаг нээлттэй байх зарчмыг баталгаажуулна.

6.Санхүүгийн эрх чөлөө.

Игэн, ААН хууль ёсны хөрөнгө, мөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, шилжүүлэх эрхтэй. Төр үнэ ханш санхүүгийн харилцаанд захиргааны аргаар үндэслэлгүй хязгаарлалт тогтоохоос зайлсхийх зарчмыг баримтална аа.

Ингэснээр санхүүгийн орчны тогтвортой байдал бэхэжнэ. Мөн хуулийн төслөөр төрийн зохицуулалтын хүрээ хязгаарыг маш маш тодорхой зааж өгсөн. Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах шаардлага тодорхой тохиолдолд гарч болно. Гэхдээ аливаа хязгаарлалт нь хуульд үндэслэсэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай, зорилгодоо нийцсэн хамгийн бага хязгаарлалттай байх ёстой.

Үүнд үндэсний аюулгүй байдал, хүний эрх, нийгмийн эрүүл мэнд, байгалийн байгаль орчны хамгаалал зэрэг зорилго хамаарна. Мөн түүнчлэн парламентын хяналт хамгаас чухал.

Хуулийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөний тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах зохицуулалтыг тусгасан байгаа. Ингэснээр эдийн засгийн эрх чөлөөний байдлыг парламентын түвшинд тогтмол хянах шинэ тогтолцоо бий болно. Энэхүү хууль батлагдсанаар аж ахуй эрхлэгчдийн хувьд бизнес эрхлэхэд илүү хялбар болж эрх зүйн орчин илүү ойлгомжтой тогтвортой болж шударга өрсөлдөөн бэхжинэ.

Хөрөнгө оруулагчдын хувьд өмчийн хамгаалалт сайжирч, эрсдэл буурч, итгэл нэмэгдэнэ. Улсын хэмжээнд хөрөнгө оруулалт, ажлын байр, бүтээмж, орлого өсөх урт хугацааны суурь нөхцөл бүрдэнэ ээ.

Эрхэм гишүүд ээ,

Бид төр төвтэй эдийн засгийн загварыг сонгох уу, эсвэл иргэн төвтэй хувийн санаачилгыг дэмжсэн эдийн засгийн тогтолцоог бэхжүүлэх үү гэсэн нэн хариуцлагатай сонголтын өмнө байна.

Эдийн засгийн эрх чөлөө бол хөгжлийн зорилго төдийгүй хөгжилд хүрэх арга зам мөн. Тиймээс үндсэн хуулийн баталгааг бодит болгож эдийн засгийн эрх чөлөөтэй Монгол Улсыг хамтдаа бүтээхийн тулд та бүхнийг дэмжин ажиллахыг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг орж ирсэн байна уу? Ариунзаяа дарга горимын санал.

А.Ариунзаяа: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор МАН-ын бүлгээс 5 хоногийн завсарлага авъя.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу МАН-ын хүсэлтээр 5 хоногийн завсарлага өглөө.

Гурав. Эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээлэл сонсох

Гурав дахь асуудалдаа оръё.

Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох ёстой сайдын мэдээлэл дээр Улсын Их Хурлын дарга оролцох юм байна. Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг хэлэлцэж эхэлнэ. Монгол Улсын Их Хурлын гишүүн эрчим хүчний сайд Бадрахын Найдлаа сайд ирсэн байна.

Мэдээлэлтэй холбоотой оролцох ажлын хэсгийг танилцуулчихъя.

Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсоход оролцох ажлын хэсгийн гишүүд. Эрчим хүчний сайд Бадрахын Найдалаа ирсэн байна. Эрчим хүчний яамны ТНБД Ерэн-Өлзий. Ажлын хэсэг байрлалаа авчих.

Эрчим хүчний яамны ТНБД Ерэн-Өлзий, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Энхтүвшин, Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга Мөнхцог. Мөнхцог алга байна уу? Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны газрын дарга Цэрэнжамц, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Түвшинчулуун, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга Эрдэнэбулган, Диспетчерийн үндэсний төв ТӨК-ийн гүйцэтгэх захирал Амарсанаа, ДЦС-4 ТӨК-ийн гүйцэтгэх захирал Болдбаатар, ДЦС-3 ТӨК-ийн гүйцэтгэх захирал Сундуйжав, УБДС ТӨК-ийн гүйцэтгэх захирал Амарсанаа.

Эрчим хүчний сайд Бадрахын Найдалаа мэдээллээ танилцуулахыг урьж байна. Сайдын микрофоныг нээе.

Б.Найдалаа: Эдийн засгийн байнгын хорооны дарга болон Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье.

Эрчим хүчний салбарын өнөөгийн бодит нөхцөл байдал тулгамдсан асуудлын талаарх мэдээлэл танилцуулга болон тус салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангаж хангах учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, танилцуулга болон тус салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангах учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дунд, урт хугацааны бодлого, өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар танилцуулга хийхийг хүссэн байгаа. Тэгээд нэлээн өргөн хүрээний сэдэв учраас энэ танилцуулга яах аргагүй агуулгын хувьд урт байгаа. Би энийг танилцуулъя.

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдлын талаар:

Улсын хэмжээнд эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал 1936мвт-ад хүрсэн байгаа. Эх үүсвэрийн төрлөөр нь авч үзвэл 1566мвт-ыг 82 хувь нь нүүрсээр, 155мвт-ыг буюу 8.2 хувь нь салхин цахилгаан станцаар, 156мвт-ыг буюу 8.1 хувь нь нарны цахилгаан станцууд, 26мвт-ыг УЦС-ууд, үлдсэн цахилгаан станцууд, үлдсэн 7 мега ваттыг дизель станцууд бүрдүүлж байгаа. Монгол Улсын хэмжээнд 2025 онд цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ 12.5 кват цагт хүрсэн нь

2024 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 8.2 хувь буюу 948.6 квт цагаар өссөн үзүүлэлт юм аа. Нийт хэрэглээний 78 хувь буюу 9.8квт цагийг дотоодын эх үүсвэрүүдээс, үлдсэн 22 хувь буюу 2.7 тэрбум киловатт цагийг импортоор хангасан байна. Эрчим хүчний салбар 2025-2026 оны өвлийн их ачаалал системийн нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж нөөц тоноглолгүй аваарын горимд ажилласан бөгөөд хамгийн их ачаалал 1803мвт-ад хүрсэн. Оргил ачааллын өсөлт сүүлийн жилд дунджаар 10 орчим хувь байна аа. Бүх ДЦС-ууд суурилуулсан бүрэн хүчин чадлаараа нөөц тоноглолгүй ажиллах нь эрчим хүчний хангамжийн найдвартай байдал өндөр эрсдэлд байгааг өнгөрсөн оны 227мвт-ын хязгаарлалт үйл ажиллагааны доголдлууд харуулсан.

Улаанбаатар хотод жил дунджаар 190 квт цагийн хэрэглээ бүхий 280 гаруй барилга байгууламж төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр холбогдож байна. Нийслэлийн дулааны хэрэглээ жилд 7-8 хувиар өссөн нэмэгдэж байна. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 2025 онд нийт 10.7 сая калори дулааны эрчим хүчийг түгээсэн бөгөөд энэ нь 2024 оны гүйцэтгэлээс 5.05 хувь буюу 518.6 мянган гик калориор өссөн үзүүлэлттэй байна аа.

Сүүлийн 2 жилийн хугацаанд Улаанбаатар хотод Бөөрөлжүүтийн 300мвт-ын станц Сонгинын 80мвт, Багануурын 500мвт-ын батарей хуримтлуурын станцууд, Дорноговь аймгийн Эрдэнэ суманд 30мвт-ын нарны цахилгаан станц, Хөвсгөл аймгийн төвд 10мвт-ын нарны цахилгаан станц, Дорнод бүсийн эрчим хүчний систем Чойбалсангийн 50 мвт-ын шинэ дулааны цахилгаан станц, Тосонцэнгэлэнгийн 22мвт-ын цахилгаан станцууд ашиглалтад орсон хэдий ч цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт өндөр байгаа тул нөөц чадал ерөөсөө бүрдэж чадахгүй байгаа юм.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөсөн хугацаанд хийж дуусгах ажлын явцад хяналт тавих шаардлагатай тохиолдолд гарсан хүндрэлийг шуурхай зохицуулах мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа. Салбарын 27 төрийн өмчит үйлдвэр компаниуд 2026-2027 оны өвөлжилтийн бэлтгэл хангахад үндсэн болон тус тоноглолын их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд нийт 575.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч санхүү, хөрөнгө мөнгөний дутагдал, үнэ тарифын алдагдлаас шалтгаалан 60 хувиар бага буюу 231.5 тэрбум төгрөг л зарцуулахаар батлагдсан байгаа юм.

Шаардлагатайгаас 60 хувиар бага, олон жил их засвар хөрөнгө оруулалтын ажлын тоо, төсвийг танаж, хойшлуулж ирснээр их болон урсгал засварын чанар муудаж засвар үйлчилгээ хийх шаардлагатай үндсэн болон туслах тоноглолын тоо өсөж энэ хэмжээгээр эрсдэл нэмэгдэж байна. 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар өвөлжилтийн бэлтгэл ажил 26 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үеийнхээс 2 хувиар бага байна. 2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, салбарын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд үйлдвэр, компаниудад батлагдаагүй, хасагдсан нийт 343.6 тэрбум төгрөг. Түүнчлэн эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний найдвартай ажиллагааг дээшлүүлэх өссөн нэмэгдэх хэрэглээг хангах зорилгоор 2026-2030 онуудад дулааны 3, 4 дүгээр цахилгаан станцын зуухны шинэчлэлд 518.9 тэрбум төгрөг, цахилгаан дамжуулах, түгээх дэд станц, шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлд 320.6 тэрбум төгрөг дулаан дамжуулах шугамын

өргөтгөл шинэчлэлт 601.3 тэрбум төгрөг буюу нийт 1 их наяд 440.8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

Энэ шаардлагатай санхүүжилтээс 2026 онд 360.2 тэрбум төгрөгийг шийдвэрлэх шаардлагатай байна аа.

Төвийн бүсийн ДЦС, дулааны станцуудын эрчим хүчний нүүрс нийлүүлэгч Багануур ХК, Шивээ овоо ХК, Шарын гол ХК-удын уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл дунджаар 44.3 хувьтай явж байна. Орон нутгийн дулааны станц тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нийт 18 уурхай нүүрс нийлүүлж байгаа ба нүүрсний уурхайнуудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Эрчим хүчний салбарын нүүрсний хэрэглээ 2025 онд 10.5 сая тонн байсан бол 2026 оны төлөвлөгөөгөөр 11.2 сая тонн нүүрс хэрэглэх төлөвлөгөөтэй байна аа.

Одоо өвлийн оргил ачааллыг даван туулах талаар:

2026-2027 оны өвлийн их ачааллын горимд ажиллагааны үед горимын ажиллагааны үед оргил ачааллыг 12 дугаар сард 1956мвт хүрэх тооцоолол гарсан байгаа. Үүний дотоодын эх үүсвэрүүдээс 1445мвт-ын батарей хуримтлуураас 150 58мвт, импортоор 353мвт тус тус хангаж ажиллана.

Салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангах үүсэж болшгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ирэх өвлийг хүндрэл багатай давахын тулд дараах богино хугацаанд хэрэгжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Үүнд:

Нэгдүгээрт нийт 200мвт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц 135мвт, 440мвт цагийн багтаамжтай батарей хуримтлуур бүхий төслийг 5 байршилд өрсөлдөөнт сонгон шалгаруулалт буюу аукционоор шалгаруулахаар хэрэгжүүлж 2026 оны 12 дугаар сард ашиглалтад оруулна аа.

Сэлэнгийн 70мвт ДЦС-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьтай хэрэгжиж байгаа ба 2026 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Мөн БНХАУ-аас зэс буюу 220 киловольтын дэд станцаар дамжуулан 80мвт-ын чадлыг импортоор авах ажлыг 2026 оны 6 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Техникийн комисс ажиллаж Монгол Улсын төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс зэс соёо хуваарилах байгууламжийг залгаж хүчдэл дор 72 цаг туршсан гүйцэтгэл 95 хувьтай байна. Дээрх богино хугацааны арга хэмжээнд авч ирүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа хэдий ч станцууд бүрэн хүчин чадлаараа бэлтгэл тоноглолгүй ажиллах тул үндсэн тоноглол дээр гэмтэл саатал гарсан үед хэрэглэгчдийг хязгаарлах асуудал эрсдэл байсаар байгаа.

Гарч болзошгүй ачаалал хязгаарлах эрсдэлийг хэд хэдэн нөхцөлөөр тооцож үзсэн бөгөөд тухайлбал хамгийн хүнд нөхцөлөөр Сэлэнгийн 70мвт-ын ДЦС ашиглалтад орохгүй. БНХАУ-аас авах 80мвт бас авч чадахгүй. Бөөрөлжүүтийн ДЦС жишээ нь өнгөрсөн жилд тохиолдсон шиг нэг блокт зогсох ДЦС-4 дээр нэг үндсэн тоног зогсоход 290мвт-ын чадал хязгаарлахаар ийм эрсдэл байгаа юм. Иймд өвлийн оргил ачааллын үед чадлын дутагдалд орж эрчим хүчээр хязгаарлах

эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор Засгийн газрын 2026 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар эрчим хүчний салбарын өвөлжилт авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулгыг хэлэлцүүлэн Засгийн газрын 2026 оны 235 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд эрчим хүчний салбарыг 2027 оны 2 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

Цаашид дунд хугацаанд чадлын дутагдлаас гарах нөөц чадлын зохистой хэмжээнд хүргэх хүрээнд эрчим хүчний суурь горимд ажиллах Баянгийн 660мвт-цахилгаан станцын эхний 330 30мвт-ын блокийг 2027 оны 7 дугаар сард, 2 дахь 330мвт-ын блокийг 2028 онд, Бөөрөлжүүтийн 3 дахь 150мвт-ын блокийг 2027 онд, 4 дэх 150мвт-ын блокийг 2028 онд, ДЦС 2-ын дэд бүтцийг түшиглэн 300мвт-ын Дулааны 5 дугаар цахилгаан станцыг 2028 онд, Даланзадгадын 50мвт-ын ДЦС-ыг 2028 онд, Дарханы өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах эрчим хүчний 2 дахь эх үүсвэрийг мөн Шивээ-Овоогийн 660мвт-ын цахилгаан станцыг 2029 онд, Таван толгойн 450мвт-ын цахилгаан станцыг 2029 онд тус тус ашиглалтад оруулахаар ажиллаж байна аа.

Салбарт тулгамдаж буй асуудлуудын талаар.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт технологийн хөгжилтэй уялдан улсын хэмжээнд эрчим хүчний хэрэглээ жилээс жилд тасралтгүй өсөж байна. Улсын хэмжээнд хэрэгжиж буй цахим шилжилт, ногоон шилжилт, цахилгаан тээвэр зэрэг бодлогын зохицуулалтын хүрээнд төлөвлөж буй салбар тус бүрийн болон бүс орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөөс харахад эрчим хүчний хэрэглээний энэхүү өсөлтийн хурд ойрын жилүүдэд улам нэмэгдэх хандлагатай байгаа юм.

2030 он хүртэл хугацаанд эрчим хүчний салбарт хамгийн багадаа суурь горимд ажиллах 1240мвт-ын чадал шаардагдаж байгаа бөгөөд энэ нь мөн өвлийн оргил ачааллын саруудад 20 хувийн чадлын нөөц бүрдүүлэх боломжийг хязгаарлаж байгаа. Түүнчлэн Улаанбаатар хотод агаарын температур -35 хэмээс доош хүйтэрсэн нөхцөлд дулаан хангамжийн системд чадлын дутагдалд орж төвлөрсөн дулаан хангамжийн системд хүндрэл үүсэх эрсдэл өндөр хэвээр байгаа юм аа. Эрчим хүчний нэгдсэн системийн суурь горимд ажиллах ДЦС-ын хөрөнгө оруулалтыг босгоход уур амьсгалын өөрчлөлтийг сааруулалттай холбоотой олон улсын бодлоготой холбоотойгоор банк санхүүгийн байгууллагуудын зүгээс тавигдах шаардлага өндөр, Засгийн газрын баталгаа зайлшгүй шаарддаг төдийгүй энэ салбарын үнэ тарифын тогтолцоонд хөрөнгө оруулагчдын эрсдэлийг нэмэгдүүлдэг зэргээс эрчим хүчний салбарын төслүүдийн хэрэгжилт удаашралтай байгаа юм аа. Эдгээр эрчим хүчний салбарт тулгарч байгаа асуудлуудыг шийдэхэд зөвхөн үнэ тариф биш гэдэг нь бид нарын өнгөрсөн түүхээр туршлагаар нотлогдсон.

Тийм болохоор бид нар эрчим хүчний салбарт цогц шинэчлэлийн бодлогыг нэлээн өргөн хүрээнд зэрэг зэрэг бодлогын арга хэмжээ авахгүй бол зөвхөн үнэ тариф эсвэл зөвхөн зардал аль нэг шийдлийг нь явахгүй ээ. Тийм болохоор бид нар нэг бодлого, 3 зарчим, 9 ажил гэсэн бодлогын хүрээнд иж бүрэн хэмжээнд аваад ажиллаж байгаа.

Д.Үүрийнтуяа: Сайдын цагийг нэмж өгье, микрофоныг өгье.

Б.Найдалаа: Товчхон дуусгая аа. Саяын бүх асуудлыг шийдэхэд тэр цогцоор нь 139 гээд байгаа нэг бодлого, 3 зарчим, 9 ажлыг л нэгэн зэрэг хийх юм байна лээ. Нэг бодлого гэж байгаа дээр нь та бүхэнд гишүүдэд дахиад дараа дэлгэрэнгүй мэдээлэл өгч ярилцана гэж бодож байгаа.

Нэг бодлого гэж байгаа нь Монгол Улсын эрчим хүчний салбар зөвхөн ойрын хугацааны өөрийн жижиг зах зээлийн хомсдолыг арилгах биш энэ яваандаа шийдэх асуудал. Гол нь цаашдаа эрчим хүчний салбар бол бүс нутгийн хэмжээнд эрчим хүчний хамтын ажиллагааг өргөжүүлсэн эрчим хүчийг экспортолсон ер нь экспортлох, эдийн засгийг үйлдвэрлэлийг өсгөх нэг том салбар гэж харах ёстой юм байна лээ. Тэгээд энэ дээр их олон гишүүд санал нэг байдаг. Тэгээд энэндээ юуг харж байгаа вэ гэхээр 1 дүгээрт энэ удахгүй болох Коп-17-ийн хурлаас өмнө батлаад амжуулаад бид нар шилжилтийн стратегийг батална. Эрчим хүчний шилжилтийн стратеги ер нь 2050 он хүртэл Монгол Улс эрчим хүчээ юунаас гаргаж авах юм цөмийн станцыг яах юм? Устөрөгчийн станцыг яах юм? Хог хаягдлын станцыг яах юм? Нар, цахилгаан станц, нар, салхи бүгдийг нь нэг оруулсан нэг ийм тооцоолол бид нар хийсэн байгаа. Удахгүй Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Энийг батална аа.

Энэ дотор зүгээр онцолж хэлэхэд нэг хоёрхон зүйл байгаа. Эрчим хүчний ирээдүй гэж байгаа. Устөрөгчийн салбарыг устөрөгчийн стратегийг энэнтэй хамт боловсруулсан байгаа. Батална. Мөн эрчим хүчний экспортын асуудал. Экспорт гэж байгаа нь зөвхөн эрчим хүч цахилгааныг дамжуулаад үйлдвэрлээд дамжуулах тухай биш эрчим хүчний өртөг дээр суурилсан хүнд, хөнгөн, дата центр гээд аж үйлдвэрүүдийг хөгжүүлэх ийм хөрөнгө оруулалтын аж үйл үйлдвэрийн паркийн шинэ концептыг эрчимтэй дэмжиж ажиллах ёстой гэж үзэж байгаа. Ямар ч байсан Монгол Улс бүс нутгийн хэмжээнд эрчим хүчнийхээ асар их нөөц дээрээ тулгуурлаад манлайлах, идэвхтэй оролцох ийм үүрэгтэй байх ёстой гэж бид нар үзэж байгаад энэ чиглэлээр ажиллаад явж байгаа юм аа. 9 ажлыг би маш товчхон дурдчихъя.

Хамгийн чухал нь бүүр хамгийн чухал нь тарифын бодлого. Энэ зах зээлийн шинэчлэл байгаа. Тарифын бодлогоо эрчим хүчнийхээ салбарын өрсөлдөх чадвар, өртөгтөө нийцүүлэх, дээр нь бас иргэдэд дарамтгүйгээр зохистой түвшинд аваачих нь бид нарын нийт Монгол Улсын салбарын хамгийн тулгамдсан асуудал байгаа. Энэ дээр тусгай нэг ажил болгоод хийж байгаа.

Хоёр дахь нь ухаалаг болох. Өнөөдрийн байдлаар нийт тоо хэрэглэгчдийн 60 орчим хувь нь ухаалаг тоолууртай болсон байгаа. Энэ ондоо багтаагаад 100 хувь болгоно. Хамгийн гол нь тоолууртай болохоосоо гадна энийг ухаалаг системд оруулаад системийн хэмжээнд болон хэрэглэгчийн түвшинд мэдээллээ ил тод авдаг, хэрэглээгээ зохицуулдаг, төлбөрөө хянадаг хүн очиж залгадаггүй хүн очиж цахилгаан бичдэггүй, хүн очиж нэхдэггүй мессеж дээр хүртэл хэрэглэгчдэд чиглэсэн зөв мессеж явдаг ийм системийг хийж байгаа. Энэ ухаалаг ажил 2 дахь байгаа.

Гурав дахь нь тархмал эх үүсвэр.

Монгол Улсын тархмал бүтэцтэй.

Цаг дуусаж байна яах вэ даргаа.

Д.Үүрийнтуяа: Багтаагаад л дуусгамаар байна. Асуултад хариулах замаар. Нэг минут өгье. Та энд багтаагаад дуусгачхаарай.

Б.Найдалаа: Байнгын хорооны гишүүдэд нарийн мэдээлэл өгч ярилцана аа. Тархмал эх үүсвэрийг дэмжих ийм бодлого байна. Дараа нь мэдээж хэрэг энэ эрчим хүчний үүсвэр дэд бүтцийг тасралтгүй эх үүсвэр үл харгалзан мэдээжээр сэргээгдэх ч юм уу, түлхүү дэмжих, шуурхай явуулах, ёстой байгаа. Шинэ технологи, шинэ эрчим хүчийг файлот хийх турших тэрийг онцгой бодлого болгож байгаа. Хувийн хэвшил хөрөнгө оруулалтын оролцоог онцгой нэмэх, хөрөнгө оруулалтыг татах дээр ажиллаж байна. Мөн чухал зүйл бол салбарын 17800 хүн байгаа. Хүний нөөцийн бодлого үнэхээр алдагдсан байгаа.

Сургалт, чадавхжуулах, дадлагажуулах ер нь хүнээ орхисон салбарт хөгжил гэж байхгүй ээ. Бас нэг чухал зүйл бол салбарын засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, өртгийг бууруулах нь энэ үнэ нэмэхээс илүү чухал ажлыг бид нар үзэж байгаа.

Мэдээж хамгийн сүүлд нь энэ бүгдийг нийлүүлээд хууль эрх зүйн орчныг шинэчлэлийг иж бүрнээр нь хийх ёстой. Энэ бүх ажлыг нэгэн зэрэг хийж байж түрүүний ярьдаг бүх асуудал шийдэгдэх юм гэдэг дээр бид нар ажиллаад явж байна аа. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт, үг хамт хамтдаа байна. Асуулт асууж үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Уянга гишүүнээр тасаллаа. Ирцээр нь эрэмбэлье. Уянга гишүүн асуултаа асууя. Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Эрчим хүчний яамныханд энэ өдрийн мэнд хүргэе. Мэдээлэлтэй нь танилцлаа. Танай танилцуулга яг слайд хэлбэрээрээ нэлээн дэлгэрэнгүй нэлээн их мэдээлэл агуулсан юм байна. Тэгээд нэлээн сайн танилцаж байгаад эргээгээд нэг зүйлийн талаар тодруулмаар байгаа юм. Тэрийг та урьтал болгоод өөрт байгаа мэдээллүүдээ хэлээд өгөөрэй. Бөөрөлжүүтийн ДЦС 150мвт орчихсон тиймээ. 300 орчихсон. 600 хүрэх ёстой. Тэгэхээр хэзээ хүрэх үү 600 руу. Тэрэндээ хариулт аваад та тэмдэглэлд оруулах нь зүйтэй байх аа.

Ингээд эрчим хүчний салбарт юу юу хэрэгтэй байна вэ гээд 9 ажлыг жагсаажээ. Хамгийн сүүлд нь хууль эрх зүйн орчны шинэчлэл гэж орсон байх юм. Энэ зүгээр эрэмбээрээ жагсаагаагүй байлтай. Эрчим хүчний тухай хууль 2001 оны 2 дугаар сарын 1-ний хууль юм байна. Одоо Эрчим хүчний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд нэг төсөл хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн дээ. Тэр маань хаана явдаг юм бол? Эрчим хүчний тухай хууль ярьж байгаа шүү. 2001 оны 2 дугаар сарын 1-нд батлагдсанаараа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа юм байна аа. Тэгэхээр хууль эрх зүйн орчны шинэчлэл дээрээ шаардлагатай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийнэ ээ. Салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг иж бүрэн хийнэ гэсэн байна. Хэзээ хийх вэ?

Орж ирсэн байгаа хуулиудаа хэрхэн уялдуулах вэ? Ингээд хариултаа авъя.

Д.Үүрийнтуяа: Найдалаа сайд хариулъя.

Б.Найдалаа: Эхнээс нь хариулъя Уянгаа гишүүний асуултад.

Бөөрөлжүүтийн ДЦС-ын эхний 2 блок нь ашиглалтад орсон одоо 300мвт ажиллаж байгаа. Ирэх оны 7 сард дараагийн блок 150мвт, тэрний дараа жил 28 онд дараагийн 150 ороод ингээд 600 болох төлөвлөгөөтэй байгаа. Төлөвлөгөөний дагуу явж байгаа. Хуулийн хувьд яг та ёстой яг онож асуулаа. Энэ дээр яг ийм тайлбар байгаа юм. Зориудаар хамгийн сүүлд оруулсан нь яагаад гэвэл хууль эрх зүйн орчин гээд хуулийг шинэчлэх нэг ийм цогц бүрэн ажил байгаа. Энийг хийж байж бүх ажил хийх юм шиг асуудал шийдэх юм шиг хандах юм бол олон ажил хаягдах гээд байгаа юм.

Тийм болохоор зориуд сүүлд нь оруулсан юм. Энийг орхино гэсэн үг биш. Ингээд хийгээд тооцоо судалгаатай хийгээд явах юм байгаа юм. Эцсийн дүндээ яг хуулийг ингээд хийх ажил нь тодорхой байгаад асуудал нь тодорхой байх юм бол хуулийн өөрчлөлт нь өөрөө гараад ирэх юм байна лээ. Тэгэхээр хийнгээ иж бүрэн хуулийн шинэчлэлийг хүлээлгүйгээр ажлаа хийгээд явах одоогийн хуулийн орчинд хийх боломж ажил олон байгаа. Ихэнх ажил нь одоогийн хуулийн хүрээнд хийхэд ердөөсөө саад байхгүй байгаа юм аа. Тэрийг орхигдуулаагүй. Тухайлбал Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн ажлын хэсгийг өнгөрсөн 7 хоногт баталсан. Өөрөөр хэлбэл, үнэ тариф холбоотой, үр ашигтай холбоотой хамгийн чухал зохицуулалтыг бид нар анхдагч хууль юм уу эсвэл ингээд нэлээн томоохон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд хараад ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр таны санаа зовниж байгаа зүйлд яг би санал нэг байна. Энийг зэрэг одоо хийгээд явж байгаа. Гэхдээ зүгээр хуулийн том өөрчлөлтийг хийгээд, судалгаа хийгээд, тэрийгээ хүлээгээд ажлаа зогсоохгүйн тулд энэ ажлуудаа одоогийн хуулийн хүрээнд хийнэ гэсэн үүднээсээ 9 дүгээрт нь тавиад 2 дугаарт ажлуудаа багцлаад тодорхой болгочих юм бол хуулийн заалтууд өөрөө шинэчлээд ороод ирэх юм байна гэсэн зарчмаар ажиллаж байгаа юм аа.

Д.Үүрийнтуяа: Уянгаа гишүүн тодруулъя.

Б.Уянгаа: Ди парламент дээр Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гээд Засгийн газраас өргөн барьсан 2025 оны 6 сарын 26-ны өдрийн төсөл байна аа. Хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн. Энэ хуулийн маань төсөл хаана явж байгаа юм бол? Цааш нь ажлын хэсэг нь гараад ажиллаж байгаа юм болов уу? Энэ дээр тодруулга мэдээлэл авъя.

Д.Үүрийнтуяа: ТНБД Ерэн-Өлзий дарга хариулъя. Индэр дээрээс гарч хариулах нь байна шүү. Индэрийн микрофоноос.

Б.Ерэн-Өлзий: Уянгаа гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны ТНБД Ерэн-Өлзий. 2025 оны 6 сард Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Гол агуулга нь болохоор Эрчим хүчний хууль дээрээ нүүрсний эх үүсвэрүүдийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэх ийм хуулийн гарцыг нээе гэсэн зорилготой. Энэний гол шалтгаан нь болохоор Таван толгойн цахилгаан станцыг тендерийг зарлаж гэхээр одоогийн худалдан авалтын хуулиар бол ерөөсөө энэ цогц ийм төслийг зарлах ийм боломжгүй болчихоод байгаа юм. Зураг төслийг нь хийх, тоног

төхөөрөмжийг нийлүүлэх, барилга угсралтыг зүгшрүүлэлтийг хийгээд түлхүүр гардуулах нөхцөлөөр хүлээлгэж өгөх.

Тэгэхээр энэ худалдан авалтын хуулиар энэ төслүүд маань сонгон шалгаруулалт хийх ч боломжгүй байсан болохоор тухайн үед бол Эрчим хүчнийхээ хуулийн хүрээнд энэ нүүрсний эх үүсвэрүүдийг сонгон шалгаруулах гарц гаргалгаа.

Д.Үүрийнтуяа: Уянга гишүүн дахин нэг тодруулах боломж байгаа. Тодорхой хариулт өгье гишүүний асуултад.

Б.Ерэн-Өлзий: Хуулийн төсөл одоо Эдийн засгийн байнгын хороон дээр байгаа. Бидний Таван толгойн станцтай холбоотой Засгийн газар дээр энэ 2026 оны 4 сард нэг шийдвэр гарсан. Энийг сонгон шалгаруулалтаар Худалдан авалтын хуулиараа явуулах биш Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар явуулъя гэсэн Засгийн газрын тогтоол гарсан. Тэгэхээр заавал сонгон шалгаруулалт хийхгүй Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжээд тэгээд манайхаас бүх мэдээллээ өгсөн. Тэнд төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явуулах ажлын процесс нь эхэлчихсэн байгаа. Нэг талаар тэгж хэлж болно.

Д.Үүрийнтуяа: Очирбат ишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Манай ХҮН намаас эрчим хүчний сайдтай болсон. Энэ чинь юу билээ 2027 билүү 2028 онд нөгөө экспортод бага эрчим хүч гаргана гээд танай намын дарга нэг яриад байсан. Тэр маань юу болж байгаа юм. 1 дэх асуулт.

Хоёрт гэх юм бол энэ 21 аймаг 9 дүүргийн хороогоороо сумаараа хэдий хэмжээний киловатт хэрэглэж байна тэр тооцоог сонсчихмоор байна. Бид нар энд тархмал эх үүсвэр гээд ярьсан. Тоогоо бүрэн гаргаж чаддаггүй. Энэ Чойжилсүрэн сайд байхад хүртэл би асууж байсан. Одоо энэ дээр дандаа нэг ийм ерөнхий юм. Тэгэхээр 21 аймаг 9 дүүргээр иргэдийн эрчим хүчний хэрэглээ нэг. ААН-ийн эрчим хүчний хэрэглээ хоёр, уул уурхайн салбарын эрчим хүчний хэрэглээ гурав. Энэ 3 дээр хэрэглээ нь яг хэд хүрч байна асуучихъя, нэг.

Хоёр гэх юм бол үнэ тарифыг тодорхой болгох хэрэгтэй. Иргэд хэдээр хэрэглэж байгаа юм, ААН хэдээр хэрэглэж байгаа юм, уул уурхайн салбар хэдээр хэрэглэж байгаа юм. Тэгээд дунд дундаж үнээ гаргаж ирээд хэдүүлээ ярья аа. Тэгэхгүй бол одоо нэг л их хямдхан энэ эрчим хүч хэрэглэж байгаа юм шиг нэг баахан хүмүүс рүү мессеж явуулдаг.

Тэгээд яг амьдрал дээр тэр ААН-үүд чинь наад эрчим хүчний салбарын чинь үнийн өсөлтөд бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж чадахгүй, гадна дотнын зах зээлтэй өрсөлдөх гэхээр өртөг нь өндөр болчихоод үйлдвэрүүд зогсож байна шүү дээ. Энэ дээр юу хариулт авчихъя.

Дараагийнх нь та сайд болсноос хойш яг юу хийв ээ? Таны өгч байгаа мэдээллээр бол энэ чинь өвөлжилтийн бэлтгэл ажил өмнөх оныхоос 2 хувиар бүүр ингээд хоцрогдолтой явж байна гэж байна шүү дээ. Үгүй тэр Чойжилсүрэн сайд чинь тухайн үед байхдаа л бид нар хийх гээд байна гээд л тэгсэн. Та чинь авчих юм бол бараг бүгдийг нь болгоод л эрчим хүчээ экспортлоод л танайхан чинь ална гээд тэгээд байсан. Одоо нөгөө алах юм чинь бүр өвөлжилтийн бэлтгэл ажил нь 2 хувиар

хоцорчихсон явж байх юм. Энэ ямар учир шалтгааны улмаас 2 хувь хоцроод байгаа юм? Ингээд энэ 3 дахь асуудал.

Дөрөв дэх нь. Ер нь одоо энэ та энэ 5 газарт байршил дээр сэргээгдэх эрчим хүчний төсөл тендер зарласан юм байна эхний ажил болгоод. Ямар үнийн саналууд ирээд байгаа юм. Энийгээ нээлттэй хэдүүлээ яримаар байна. Та өнөөдөр эрчим хүчний салбар үнэ нь болохгүй байна өртөгтөө хүрэхгүй байна гээд байдаг. Энэ ААН-үүд танд ер нь ямар санал өгөөд байгаа юм. 1квт-ын төв рүү 285 төгрөгөөр нийлүүлье гээд байгаа юм уу, 300-аар нийлүүлье гээд байгаа юм уу? Хэдэн жилийн хугацаатай гэж байгаа юм. Энийг 4 дэх нь асуучихъя.

Тав дахь нь олон жил бид нар ярьсан. Энэ супер эрчим хүчний сүлжээ рүү холбогдоно гээд л ярьдаг. Хятадууд хөрөнгө оруулалт хийгээд бараг энэ 20 гига батыг хийгээд Монгол Улсад 3, 4 гига батыг нь үнэ төлбөргүй өгнө, үлдсэнийг нь урагшаагаа аж үйлдвэрийнхээ салбар руу авна гээд л ярьдаг. Энэ яриа уулзалтууд чинь ер нь ямар байгаа юм. Ард иргэдэд нэг нээлттэй, ил тод нэг хэлээд өгөөч. Энэ 5 асуултдаа хариулт авчхаад тодруулж үг хэлье.

Д.Үүрийнтуяа: Найдалаа сайд хариулъя.

Б.Найдалаа: Эрчим хүчний экспортын асуудал түрүүн би дурдсан. Эрчим хүчний экспорт бол Монгол Улсын хөгжлийн тэр дотроо эрчим хүчний салбарын хөгжлийн сэргэлтийн үндсэн чиглэл гарцаагүй нэг барих ёстой бодлого стратеги мөн. Энэ чиглэлээр ажиллаад явж байна аа. Эрчим хүч шилжилтийн стратегид оруулсан байгаа. Эрчим хүчний экспорт гэдгийг зөвхөн цахилгаан станц бариад, шугам татаад цахилгаан дамжуулах тухай ярихгүй ээ. Энэ дээр устөрөгчийн стратеги байх ёстой. Устөрөгчийн эрчим хүчийг хөгжүүлэх ёстой аммиак, аммоневр тээвэрлэдэг энэ бүс нутгийн хэмжээний угаасаа ирээдүйг харсан бодлого нь тэгж явж байна.

Гуравт нь эрчим хүчний өртөг дээр суурилсан хөнгөн цагаан, дата центр ийм аж үйлдвэрийн паркийг хөгжүүлэх нь Монгол Улсын эрчим хүчний экспортын бодлогын нэг хэсэг юм. Тэгээд энэ энэ цогц ажил. Тэгээд 1 амьсгаагаар ухасхийгээд хийчихдэг ажил биш гэдгийг та эрхбиш ойлгож байгаа байх. Тийм болохоор энэ чиглэлээр ажиллаж байгаа. Тэгээд гишүүдээс энэ дээр санал бодлогын дэмжлэг авч ажиллана аа. Энэ бол шууд ингээд хэлэхэд хэлдэг зүйл биш Очирбат гишүүнээ. Энэ тооцооллыг бас хийнэ. Энийг чинь ингээд зүгээр бид нар хэдэн тонн мах нийлүүлэх экспортлохоо ч тоолж гаргахад хэцүү байдаг шүү дээ.

Тэгэхээр бизнесийн юман дээр та ийм юм мэдэх байх. Тэгээд энийг бол тодорхой тоо хэлэх нь зохисгүй бөгөөд гэж сайн тооцож байж батлуулж байж ярих байх аа. Өвөлжилтийн бэлтгэл яг одоогийнхоо нөөц боломждоо цаг хугацаандаа хэвийн явж байгаа. Зүгээр энэн дээр зүгээр бас эрчим хүчний өвөлжилтийн чадлын дутагдлыг тухайлбал л хэн нэгэн ухаантай хүн ч юм уу зүгээр нэг бяртай хүн ч юм уу ухасхийгээд хийчихдэг зүйл ердөөсөө биш.

Энэ бол цагийн юмыг цагт нь хийгээгүйгээс олон жилийн, бүр олон 10 жилийн бодлогын алдааны хуримтлагдсан асуудал юм шүү. Тэгэхээр энэ дээр бид нар хэн нэгнийг буруутгахдаа биш одоо яах юм гэдгээ ажил хэрэгчээр тооцоо судалгаан дээр үндэслээд бас улс төрийн зоригтойгоор алхмуудаа хурдан хийх ёс тай юм аа. Тийм болохоор бид нар иж бүрэн 1, 3, 9 гэсэн бодлого гаргаад ажиллаж байгаа.

Таван газрын тэр авагдсан Монгол Улсад анх удаа явагдаж байна. Энэн дээр үнэ тариф дээр нь суурилж хийж байгаа авагдсан үнэ. Өөрөөр хэлбэл үнэ тарифыг бууруулахын тулд шударга өрсөлдөөнийг бий болгохын тулд 5 газрын авагдсан үнэ зарлаж байгаа. Цаашдаа энэ жишгээр ингээд явна. Юу гэсэн үг вэ гэхээр таны асуугаад байгаа үнээ ингээд илээр тавьдаг биш, үнийг бол нөгөөдөр 4 дэх өдөр ил тод лайв үзүүлээд ингээд дуудлага худалдаа хийнэ. Өөрөөр хэлбэл олон нийтэд, ард түмэнд нээлттэйгээр хэн хэдийн үнэ өгсөн гээд энийг сонгон шалгаруулах юм аа.

Тэгэхээр энийг бол та тэрийг сонирхоод үзээрэй. Энэ дээр бол бүх юм тодорхой болно оо. Ингээд үнэ тарифтай холбоотой тооцоонуудыг Эрчим хүчний зохицуулах хороо, түрүүний тэр дүүргийн хэрэглээтэй холбоотойг Диспетчерийн үндэсний төвөөс хариулна аа. Микрофоныг нээж өгнө үү.

Д.Үүрийнтуяа: Индэрт гаръя. Индрийн микрофоныг нээе. Албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

Ө.Түвшинчулуун: Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Түвшинчулуун Очирбат гишүүний асуултад хариулъя. Үнэ тарифын хувьд бол 2024 онд бид үнэ тарифыг бол нэмэгдүүлсэн. 2024 онд энэ үнэ тарифт өөрчлөлт орсон байгаа. 2024 оны байдлаар айл өрх бол 1 квт цаг цахилгааныг 213 төгрөг, ААНБ бол 280 төгрөг, уул уурхай бол 338 төгрөгөөр. Ингээд дундаж үнэ 280 төгрөг болсон. Ямар ч байсан 2024 оны байдлаар бид өртөгт нь хүргэсэн. Сая бол сүүлд айл өрхийн цахилгааны тарифыг бол айл өрх ААНБ-ын цахилгааны тарифыг 5 хувиар, төсвийн байгууллагын тарифыг бол 10 хувиар, уул уурхайн ангиллын тарифыг 15 хувиар нэмсэн.

Д.Үүрийнтуяа: Нэг минут нэмж өгье.

Ө.Түвшинчулуун: 213 төгрөг нь бол 224 төгрөг болсон айл өрхийнх. ААНБ-ынх 280 төгрөг нь бол 307 төгрөг болсон. Уул уурхайнх бол 338 төгрөг нь 389 төгрөг болсон. Тэгээд дундаж үнэ бол 304 төгрөг болсон байна. Хариулт дууслаа.

Д.Үүрийнтуяа: Гишүүн тодруулах уу? Ээмж гүйцээж хариулъя. Гишүүний асуултад. Орон нутгийн хэрэглээ 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд.

Ч.Амарсанаа: Диспетчерийн үндэсний төвөөс Амарсанаа байна. Ер нь Баруун бүсийн эрчим хүчний систем бол 2025 онд 165 сая квт цаг эрчим хүч хэрэглэж байсан. 2026 оны төлөвлөгөөгөөр бро 171 сая квт цаг хүрнэ. Өнгөрсөн үе үеийнхээс 3.6 хувийн өсөлттэй гарна. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээн дээр бол 4 тэрбум 897 сая квт цаг эрчим хүч 2025 онд хэрэглэж байсан бол 2026 оны их ачаалалд 5 тэрбум 237 квт цаг эрчим хүч, өсөлт нь 6.9 хувиар өснө. Баруун бүсийн эрчим хүчний системд дээр 219 сая квт цаг эрчим хүч 2025 онд хэрэглэж байсан бол энэ жил 232 сая квт цаг эрчим хүч хэрэглэнэ. 6 хувийн өсөлттэй байгаа.

Ер нь сум суурин газруудаар хэрэглээг нарийвчилж гаргаж болно. Ерөнхий сум суурин газрын хэрэглээ бол 500-аас 600 квт эрчим хүчийг хэрэглэж байгаа 24 цагийн байдлаар. Ингээд тооцож үзэж болно. Импортын цахилгаан.

Д.Үүрийнтуяа: Гүйцээж хариулъя. Импортын цахилгаан эрчим хүч бол бид нар 1 тэрүм 297 сая квт цаг эрчим хүч хэрэглэж байсан. 2026 онд бол 1 тэрбум 381 сая квт цаг эрчим хүчний хэрэглээ гарна. Энийг бол ингэж хэрэглээний өсөлтийн тухайд ингэж хариулах байна.

Д.Үүрийнтуяа: Чангахан ярихгүй бол сонсогдохгүй л байх шиг байна даа. Очирбат гишүүн тодруулах уу болсон уу? Тодруулъя. Очирбат гишүүний микрофоныг өгье.

Г.Очирбат: Тэгээд бид нар яг ийм л тоотой байгаа. Жил болгон нэг ийм бөөрөнхий юм ярьдаг, жил болгон орж ирнэ гоё юм ярьдаг. Түүрүү жил л энэ автомат энэ тарифын тоолуурын систем ярьж байсан. Одоо дахиад л орж ирж байна. Жил болгон 21 аймаг 9 дүүргийн яг тэр сумдын иргэдийн хэрэгцээ хэд байдаг юм гээд тоог гаргаж ирж хэлдэггүй. Ерөнхий нэг баруун бүсийн тэдэн сая, төвийн бүс дээр тэд гээд нэг ийм тоо яриад байдаг. Тэгэхээр нөгөө хэрэгцээгээ тодорхойлж чадаагүй байж байж яаж шийдвэр гаргах гээд байгаа юм. Эрчим хүчний салбараа бид нар либералчилъя гээд л яриад байдаг. Иргэд, ААН, төрийн бодлого энэ 3 нийлж байж цаашаагаа энэ эрчим хүчний салбар чинь өөрийн гэсэн тусгаар тогтнолоо олно. Түүнээс олж чадахгүй. Эрчим хүчний тухай хуулиараа иргэн болгонд нэг 20квт эрчим хүч үйлдвэрлэх бололцоо боломж нь гарсан. Энийгээ үлгэр дуурайлал болгоод нэг суман дээр юм уу нэг хороон дээр хийж үзүүлээч ээ. Манлайллаа харуулъя аа.

Нэг минутаа нэмээд авчихъя Үүрийнтуяа дарга.

Д.Үүрийнтуяа: Нэг минут нэмж өгье.

Г.Очирбат: Бодлогын манлайллаа харуулах хэрэгтэй байна аа. Орж ирэхээрээ дандаа мөнгө нэхэж суудаг, тархи толгойгоо ажиллуулаад бодит хэрэгцээгээ гаргаад бид нар баруун бүсийн Увс аймгийн ийм суман дээр энэ сумыг ингээд өөрчлөөд үзсэн чинь яг болж байна шүү. Өвөрхангай, Баянхонгор аймгийн төв өвөлдөө асар их утаатай байдаг. Яг энэ нэг аймгийн хэмжээнд ийм төсөл хэрэгжүүлээд үзсэн чинь болж байна шүү. Тэгээд энэ бодитой үр дүнгээ яриад цаашаагаа шийдвэр гаргаад явмаар байгаад байгаа юм. Тэгэхгүй орж ирэх болгондоо мөнгө нэхдэг, болохгүй байна гэдэг, бүтэхгүй байна гэдэг. Тэгээд та хэдийн болохгүй бүтэхгүйг сонссоор байтал энэ эрчим хүчний салбар чинь бүр доройтоод унаад дууслаа шүү дээ. Уул нь эрчим хүчний салбар чинь хамгийн л түүхий эд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд иргэдийн аж ахуйн амь амьдралд нь хамгийн хэрэгтэй салбар. Тэгээд энэ дээр бодитой шийдвэр гаргаад явж чадахгүй ийм байдалтай танай салбар байгаа. Тэгээд эрчим хүчээ экспортлохыг Найдалаа сайдад хүсье, үг чинь үнэн байх болтугай.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт дарга асуулт асууж, үг хэлнэ. Микрофоныг өгье.

С.Бямбацогт: Тийм цаг үеэ олсон нэн шаардлагатай учраас Улсын Их Хурлын асуудлыг сонсож байгаа. Тэгээд асуудалтай ч юм шиг асуудалгүй ч юм шиг, ажил хийгээд байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг их л ерөнхий байна? Сая Очирбат гишүүний хэлж байгаа үнэн. Ерөнхий биш нь маш тодорхой шийдэлтэй л юм яримаар байна. Энийг би танилцуулга дээр биччихсэн байна шүү дээ.

2 мянган Мвт-аа эрчим хүчний хэрэгцээ байна бидэнд үүний 300мвт нь дутна. 1700мвт-аа бид нар шийдэж чадна гэж байна. Энэ 300мвт дутах гэж байгаа тог сумаар байвал хэдэн сум 330 сумыг хэдийг нь таслах вэ, аймгаар бол 21 аймгийг хэдийг нь таслах вэ хязгаарлах вэ? Дүүргээр ярих юм бол 9 дүүргийн хэдийг нь хязгаарлах вэ? Ямархуу асуудал үүсгэх гээд байгаа юм? Энийгээ ойлгомжтой тодорхой болгоод ярьчихмаар байна шүү дээ. Үүнийгээ тэгээд яаж шийдэх гэж байгаа юм? Шийдлээ тодорхой ярьчихмаар байна шүү дээ. 300мвт маш том тоо. Өнгөрсөн өвөл бид нар эрчим хүчний хязгаарлалтад орсон оргил ачааллын үедээ. Яг энэнтэй адилхан давтагдах гээд байна. Тийм учраас Улсын Их Хурал дээр сонсож байгаа энийг нэг хариулж өгөөч.

Хоёрдугаарт нь ирэх өвөл шахмал түлш, хагас коксожсон түлш түлсэн, агаарын бохирдол буурсан. 100 мянган тонн коксожсон түлшний тендер зарласан амжилттай болон амжилтгүй болчихсон байна. Ирэх өвөл Улаанбаатар хот дахиад утаатай болох уу эс үгүй бол хагас коксожсон түлшний асуудлаа шийдэж чадах уу. Энийгээ тодорхой хариулж өгөөч.

ТЭЦ-3, ДЦС-3 өнгөрсөн жилийн өдийд дэлбэрэлт бас гарсан осол гарсан Засгийн газар, Их Хурал яаралтай мөнгийг нь шийдэж өгсөн 90 тэрбум төгрөг. Одоо дөнгөж 30 гаранхан хувийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна гэж байна. Бүтэн жил болж байхад яагаад ТЭЦ-3 буцаад засагдаад сэргээгдэхгүй байна? Хөрөнгийг нь шийдэж өгөөд байхад яагаад энэ асуудал ингээд энэ хэвээрээ байгаад байгаа юм бэ? Нэг иймэрхүү юмнууд дээр их тодорхой хариулмаар байх юм. Хэн удаагаад байгаа юм, яагаад удаад байгаа юм? Жил боллоо шүү дээ. Мөнгийг нь шийдээд өгчихсөн шүү дээ.

Дээрээс нь 500 тэрбумын тийм тарифаа нэмээд нэмээд цаана нь дахиад 500 тэрбумын өртэй байж байна. Энэ өрөө яаж шийдэх гэж байгаа юм. Өрөө шийдэж чадахгүй бол ямар эрсдэл учрах гээд байгаа юм. Шийдэх ямар шийдэл байгаа юм. 800 тэрбумын өртэй байснаас 300 тэрбумын тарифаа нэмж шийдэх юм байна. Цаад талд үлдэгдэл 500 тэрбумаа яах юм, банкнаас зээл авах юм уу эс үгүй бол яах юм.

Дээрээс нь 600 тэрбумын хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж байна. Тэгэхгүй бол осол аваар гарч магадгүй. 100 хувь хүчин чадлаараа ажиллаж байгаа гэж байна. Энэ ирэх өвлийг яаж давах вэ гэдэг асуудал бидэнд хамгийн том тулгамдсан асуудал байна шүү дээ. Бусдаар 2030 он, 2040 он хол байна тийм. Мэдээж 30, 40 оноо ярих ёстой. Гэхдээ ирэх өвлийг л бид нар яаж давах вэ? Яаж тог таслахгүй байх вэ? Улаанбаатар хот хөлдөхгүй байх вэ? Улаанбаатар хот хөлдөх, Улаанбаатар хот оргил ачааллын үеэр Монгол Улсын иргэд тогоо хязгаарлуулах ийм л асуудал үүсгэх гээд байна шүү дээ. Энийг чинь Их Хурал дээр түрүүлж хараад энэ тийм үү наадмын маргааш намар гэж ярьдаг. Одоогоос бид нар бэлтгэе гэж энэ мэдээлэл сонсож байгаа шүү дээ. Гэтэл нэг мэдээлэл дээр тийм ерөнхий хариулдаг болж байгаа ч юм шиг болохгүй байгаа ч юм шиг болохгүй байгаа юмаа ярихад дандаа л мөнгө төгрөг, зовлон ярьдаг. Шийдэл ярьдаггүй, маш тодорхой ийм ийм асуудлууд байна ингэж ингэж шийднэ. Ирэх өвөл бид нар ингээд Улаанбаатарыг хөлдөөхгүй, иргэдийг хэрэглэгчдийг тогны хязгаарлалтад оруулахгүй ээ гэдэг шийдэл л энд тодорхой ярьчихмаар байна.

Яг энэ дээр нэг тодорхой яриад өгөөч. Энд сууж байгаа хүмүүс ойлгохгүй болохоор чинь иргэд яаж ойлгох вэ? Их ерөнхий яриад байна. Тийм болохоор энийг нэг тодорхой яриад өгөөч л гэдгийг хүсэж байна.

Д.Үүрийнтуяа: Найдалаа сайд хариулъя.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгээд Бямбацогт даргад баярлалаа. Өнөөдрийн нэгэн тулгамдсан асуудлыг яах аргагүй Улсын Их Хурлаар Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэх нь үнэхээр хэр чухал байгаа цаг алдахгүй хэлэлцэх, гишүүдэд мэдээлэл өгөх, зөвхөн өнөөдрийн хурлаар биш цаашдаа илүү мэдээлэл өгье гэж бодож байгаа. Яг санал нэг байна аа. Бид нар хүссэн ч, хүсээгүй ч гаднаас импортлоод импортлоод БНХАУ-аас дахиж импортлох суваг нээгээд 80мвт-ыг хүртэл импортлоод бид нарт яах аргагүй чадлын дутагдал гарахаар байгаа. Энэ чадлын дутагдлыг 2 сарын дотор ДЦС барьж чадахгүйгээс цааш өмнө бэлтгэлийг хангаагүйгээс хойш бид нарт яах аргагүй ийм эрсдэл байгаа. Гэхдээ эрсдэлийг байлгахгүйн төлөө бид нар ажиллаж байгаа. Энэ жил орох эх үүсвэр нь бол 1 дүгээрт Сэлэнгэ аймагт баригдаж байгаа 70мвт-ын ДЦС байгаа. Мөн 2 дахь нь БНХАУ-аас импортлох боломж бүрдүүлээд хуваарилах боломжийг бүтээж байгаа 80мвт хүртэл энэ 2 нэмэгдээд өөр эх үүсвэр бид нарт яг ДЦС байхгүй. Тэгэхээр тэрийг нөхөхийн тулд маш богино хугацаанд бид нар ямар ажиллаж байна вэ гэхээр тэр 5 аймгийн маш богино хугацаанд ердөөсөө 7 сарын 1-нд зарлаад гэрээг нь хийнэ. 5 аймгийн нийт 220мвт-ын хүчин чадалтай нарны эх үүсвэр, араас нь говийн бүсэд, баруун бүсэд зүүн бүсэд маш богино хугацаанд хэрэгжүүлэхээр зарлахаар зэхэж байгаа.

Энэнтэй зэрэгцээд яах аргагүй зайлшгүй хийх ёстой зүйл доголдол гаргахгүй. Өвөлжилтийн бэлтгэлийг хангах. Энийг бол яг одоогийн байгаа төсөв тариф тарифынхаа хэмжээнд хамаг хүчээ дайчлаад эд нар ажиллаж байгаа. Кокстой холбоотой саяхан Засгийн газрын тогтоол гарсан. Эрчим хүчний салбарт нийслэлийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлаар ажиллах яах вэ? Эрчим хүчний яам гээд яг энэ коксжих нүүрс энэ утааны асуудлыг шууд хариуцдаггүй. Тэгэхдээ нийслэл бол энэ дээрээ энэ эрчим хүчний хүрээнд гаргасан өндөржүүлсэн бэлэн байдлын хүрээнд бэлтгэлийг хангаад ажиллахаар шийдвэр чиглэлээ аваад явсан байгаа. Тэр дутагдалтай холбоотой нарийн болон ТЭЦ-3-ын асуудлаар ТЭЦ-3-ын захирал Сандуйжав хариулаад явчихъя. Тэгээд хурлын дарга би энэ 3 минутаа жоохон хэмнэчихсэн болохоор энэ хариулахад минут нэмж өгсөн нь зөв байх гэж бодож байна.

Д.Үүрийнтуяа: Индрийн микрофоныг өгье. 2 минутаар.

Б.Сундуйжав: Бямбацогт даргын асуултад хариулъя.

ДЦС-3 өнгөрсөн 2025 оны 6 сарын 20-нд осол аваар гарсан. Үүнтэй холбоотойгоор бол онцгой нөхцөл байдал тогтоосон байдаг. Онцгой нөхцөл байдал тогтоосонтой холбоотойгоор маш нууцын хүрээнд 3 том багц ажил хийгдсэн. Энэ нь бол тухайн осол аваартай холбоотойгоор барилгаа битүүмжилж дээврийн ажил барилгаа нөхөн сэргээх ажил өнгөрсөн ондоо багтаж хийгдсэн. Улаанбаатар хотын дулаан хангамжийн 30-аас 32 хувийг хангадаг учраас дулаанжуулалтын тоноглолыг өнгөрсөн оны 12 сард багтаж мөн Улсын комисс ажиллуулж өнгөрсөн 2025-2026 оны дулаанаар хангах арга хэмжээг авч дулаанжуулалтын ажлыг 100 хувь хийсэн байгаа. Энэ яах вэ нөгөө маш нууцтай байсан учраас бол бүртгэл тооцоо хийх, мэдээлэл өгөх дээр бол харьцангуй хүндрэлтэй байсан. Ингээд 2 багц ажлыг 100 хувь хийсэн байгаа. Үүнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар машин буюу 25-ын труба генератор нэгийг хийх ёстой, 50мвт-ын 9 дүгээр машин

буюу 50мвт-ын труба генераторт ингээд хоёр 75мвт-ыг оруулах ёстой. 7 дугаар машины хувьд бол Монгол Улсын 2 ААН түншлэлээр орсон. Өнөөдрийн байдлаар ажил 45 хувьтай явагдаж байгаа. Үйлдвэрлэл бол үндсэн 600 хувь хийж өгсөн. Бид нар бол 7 дугаар машиныхаа буулгалтыг компанийн өөрсдийн засварчдын хүрээнд 100 хувь буулгасан.

Өнөөдрийн байдлаар бол суурийн төлөвлөлт 75 хувьтай явж байна. Нийт үндсэн тоноглол 45 хувьтай, зураг 100 хувь хийгдсэн. Гэрээгээрээ бол 12 сарын 30 бид яах вэ хэлцэл хийгээд мэдээж тоноглол ороод ирсэн тохиолдолд 10 сарын 1-нд бол 7 дугаар машины тоноглол 100 хувь Монгол Улсад орж ирнэ. Энэ тохиолдолд компанийн зүгээс инженерүүдээ хамтран туслан гүйцэтгэгчээр ажиллаж 25 магаваттыг ондоо багтааж оруулна гэсэн ийм байдалтай ажиллаж байгаа.

Есдүгээр машины хувьд бол.

Б.Сундуйжав: Гүйцээж хариулъя. Сая 14 хоногийн өмнө бол Засгийн газрын хуралдаанаар орж нууцаас гаргасан байгаа. Цаад гүйцэтгэгч компани бол нэг нь угсралтын компани. Нэг нь бол үйлдвэрлэгч 2 түншлэлээр орж ирсэн. Ингээд бид нар нууцаас гаргаад гэрээгээ хүргүүлсэн. Энэ тохиолдолд бид нар зураг бол 100 хувь хийгдсэн. Мөн бид нар буулгалтын ажлаа 100 хувь хийсэн, туслах тоноглолын үйлдвэр 40 хувьтай явж байна. Үндсэн тоноглолын үйлдвэр дөнгөж эхэлж байгаа ингээд нэг 33 хувьтай байна.

Тэгэхээр 2026 ондоо арай багтаж орохооргүй өнөөдрийн байдлаар ийм юу харагдаж байгаа. Бид нар бол 2026-2027 он гээд. 2027 оны нэг сард гэхэд нэгдсэн сүлжээнд холбоно гэсэн ийм байдалтай гүйцэтгэгч компанитай өдөр тутам харилцаад ингээд явж байна.

Д.Үүрийнтуяа: Бямбацогт дарга тодруулъя.

С.Бямбацогт: Тодорхой асуусан тодорхой хариулахгүй л байгаад байна л даа. Гэхдээ одоо тэгээд та бүхнийг ярихгүй байгаа болохоор асуудалгүй л гэж ойлгоё. Үндсэндээ ирэх өвөл Улаанбаатарчууд Монголчууд тогны хязгаарлалт, эрчим хүчний хязгаарлалтад орохгүй юм байна. Ямар нэгэн байдлаар та бүхэн шийдэж байгаа юм байна гэж. Асуудал юу байна, ямар асуудал дээр ямар шийдэл гаргаж байна гээд асуугаад байхад ерөнхийдөө болж байгаа л гэсэн тийм л хариулт өгөөд байна шүү дээ? Тийм болохоор тэгж ойлгож байна шүү. Тэгэхээр энэнтэй холбогдуулж Улсын Их Хурлаас тогтоол баталж өгье өө. Ирэх өвөл Улаанбаатарчууд болон Монгол Улсын иргэдийг хэрэглэгчдийг эрчим хүч хэрэглэгчдийг тогны хязгаарлалтад оруулахгүй байх тодорхой үүрэг даалгавар өгсөн Улсын Их Хурлаас тогтоол гаргаж өгье. Яг ийм байдлаар ингэж ийм ерөнхий байдлаар явмааргүй байна. Тийм ерөнхий байдлаар. Би сая асуусан шүү дээ. 300мвт-ын чадлын дутагдалд орох гэж байгаа бол сумаар бодвол хэдэн сум бэ, хэдэн аймаг вэ, хэдэн дүүрэг вэ, 4 цаг хязгаарлах уу? 2 цаг хязгаарлах уу? Энэ дээрээ тодорхой хариулт өгөөч гэсэн. Энд хариулт өгөхгүй байгаад байна шүү дээ. Тэгээд дээрээс нь сая ярьсан шүү дээ. Бид хэд өр авлагаа яаж шийдэх гэж байгаа юм бэ. 500 тэрбумын өртэй тийм үү? Тэгээд үнээ нэмчхээд цаана нь дахиад 500 тэрбумын өртэй болох гээд байна. Энийгээ хэрхэн яаж шийдэх гэж байгаа юм. Зайлшгүй шаардлагатай 600 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх ёстой байгаад байна. Тоноглол их засвар хийх хөрөнгө оруулалт ингээд энүүгээр чинь үзэх юм бол дор хаяж 1 их наяд гаруй төгрөгийн хэрэгцээ шаардлага та бүхэнд

байгаад байна шүү дээ. Энэ дээр ингээд хариулт байдаггүй ерөөсөө. Тийм болохоор ерөнхий биш нэг жоохон тодорхой тэгээд Их Хуралд танилцуулж байгаа юм чинь бүр зовлон жаргалаа яриад авъя. Энэ дээр тэгээд бүгдээрээ Монголчууд бүгдээрээ тал талдаа анхааръя. Их Хурал, Засгийн газар яам анхааралдаа авч байгаад энэ асуудлаа шийдүүлье. Шийдүүлэхэд нь Их Хурал ингээд дэмжээд өгөөч, Засгийн газар ингээд дэмжээд өгөөч, ард иргэд ингээд ойлгоод өгөөч гэдэг юмаа л яримаар байна шүү дээ.

Өнөөдөр ч гэсэн иргэддээ айл өрхүүддээ 140-өөр тог зарчхаад 280-аар буцааж иргэдээс тог худалдаж авч байгаа шүү дээ. Илүүдтэй тогийг нь. Бидэнд өнөөдрөөс илүүдэлтэй байж байгаа. Энэ бодлого чинь зөв юм уу? Улам л та бүгдийг санхүү хүнд байдалд оруулаад байгаа шүү дээ. Тэгээд энэ бүгдийгээ ярихгүй байгаад байх юм. Энэ чинь асуудлаа илэн далангүй ярьж байж тодорхой шийдэл гаргамаар байна шүү дээ. Тийм болохоор Улсын Их Хурлаас, Байнгын хорооноос нэг тогтоол оруулж ирье энэ дээр. Засгийн газарт чиглэл өгсөн энэ эрчим хүчийг Улаанбаатар хотыг ирэх өвөл хөлдөхгүй байх иргэд хэрэглэгчдийг эрчим хүчний хязгаарлалтад оруулахгүй байх чиглэлээр тодорхой шийдэл гаргая.

Д.Үүрийнтуяа: Хариултыг Найдалаа сайд хариулъя. Дараа нь индрийн микрофон.

Б.Найдалаа: Хугацаа бага байгаа болохоор товчхон хариулчихлаа. Бямбацогт дарга уучлаарай. Яг тодорхой, яг зөв яг яах аргагүй шулуухан хэлэхэд би олон удаа яриад байгаа. Эрчим хүч хязгаарлах эрсдэл бол байгаа, дутагдал байгаа. Энэ дээр тооцоо хийгээд үзэхэд саяын тэр Сэлэнгийнх орохгүй байлаа гэхэд Бөөрөлжүүт дахиад доголдлоо гэхэд ингээд ТЭЗ-4 дээр ч юм уу нэг доголдол гарлаа гэхэд бид нар ихээр нь тооцсон шүү 290мвт-ын дутагдал гарахаар байгаа яах аргагүй гарна. Энийг гарах юм бол эрсдэлийн менежмент би ярьж байна. Яг гарна гэж хэлээгүй. Гарах юм бол 13 багцад ингээд хуваачихсан нарийн тооцоонууд байгаа. Яг хаана хаана эрсдэл багатайгаас нь хохирол багатайгаас нь яаж хэрхэн хязгаарлах вэ? Энэ бол байнгын төлөвлөгөөтэй байдаг зүйл байгаа юм аа. Зүгээр Их Хурлын тогтоол гаргахыг би үнэхээр баярлан дэмжиж байна. Энэ дээр зүгээр асуудлуудаа иж бүрэн оруул болоод ний нуугүй дахин дахин хэлэлцээд яриад авмаар байна. Тэгээд таны энэ санаачлагад их баярлаж байна. Одоо жишээлбэл 629 тэрбумын өр энэ жил үүсэж байгаа юм. Яах аргагүй үйлдүүлж байгаа өртгөөс нь багаар.

Д.Үүрийнтуяа: Гүйцээж хариулъя. Найдалаа сайдын микрофоныг өгье.

Б.Найдалаа: Яах аргагүй үйлдүүлж байгаа өртгөөс нь илт багаар худалдаад байхаар хүссэн хүсээгүй энэ салбар цаг минут тутамд ажиллах тусмаа эрчим хүч үйлдвэрлэхээсээ илүүтэй өр төлбөр үйлдвэрлээд байгаа юм. Хэрвээ бид нар энийг зогсоохгүй бол цаашдаа бид нар эрчим хүчний найдвартай байдал, эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт, шинэ орон сууц ярих тухай ямар ч боломжгүй болох юм аа. Тийм болохоор энэ дээр бодлогын дорвитой, шинэчлэлийн, улс төрийн зоригтой алхам хийхгүй бол бид нар энэ байх байдлаасаа гарч чадахгүй юм аа. Тэгэхээр энэ бол эхний ээлжид үнэ тарифын асуудал. Үнэ тарифыг бид нар ингэж харж байгаа юм. Зөвхөн өртөгт нь нийцүүлээд нэмэх тухай асуудал биш ээ. Ялангуяа Эрчим хүчний яамны хувьд эрчим хүчний үйлдвэрлэлийн өртгийг бид нар хянаж байгаа.

Өртгийг өөрөөр хэлбэл бид нар хамгийн бага зардлаар үйлдвэрлэж чадаж байна уу, нөгөө ярьдаг шүүмжилдэг хулгай зэлгий байна уу үр ашиггүй орон тоо байна уу, компанийн засаглал сайн байна уу гэдэг дээр бид нар эхний ээлжид төвлөрч ажиллаж байгаа. Үүнтэй зэрэгцээд Эрчим хүчний зохицуулах хороо тооцоо судалгаа.

Д.Үүрийнтуяа: Индрийн микрофоныг өгье.

С.Цэрэнэжамц: Эрчим хүчний яам Цэрэнжамц Бямбацогт даргын асуултад хариулья аа. 4 дүгээр цахилгаан станц дээр 70мвт-ын нэг турбин нь эвдрэхэд саатахад бид 1.5 мянган ААН, 25 мянган айл өрхийг 8 цаг хязгаарлана. Энэ нөгөө эрсдэлийн менежмент болж гаргаж байгаа тоо учраас та бүхэн зөвөөр ойлгоорой. Сэлэнгийн 70мвт ороогүй, 4 дүгээр станц дээр нэг блок гэмтсэн. Бөөрөлжүүтийн нэг турбин ажиллагаанд ороогүй тохиолдолд 290мвт-ын дутагдал үүснэ ээ. Энэ дээр нэг цаг орчим бид 4.4 мянган ААН 80 мянган айл өрхийг үндсэндээ хязгаарлалтын горимд оруулна аа. Яг энэ тохиолдлоор бид нар бол нийтдээ нэг 14 багцад хуваачихсан байгаа. Хэрэглэгчийнхээ зэрэглэлээс хамаараад хязгаарлалтын горим хийгээд явна аа. Хамгийн хүнд нөхцөл бол 506мвт энэ нь болохоор Сэлэнгийн.

Д.Үүрийнтуяа: Индрийн микрофоныг нэг минут нэмж өгье.

С.Цэрэнжамц: БНХАУ-ын импорт байхгүй. 4 дүгээр станц Бөөрөлжүүтийн 1 блок гэмтсэн тохиолдолд бид 1 цагт 7.5 мянган ААН, 90 мянган айл өрхийг хязгаарлах нийтдээ 24 багц ийм төлөвлөгөө гаргасан ажиллаж байгаа. Ер нь бол бид өнөөдөр Оюу Толгойтой 80мвт-ыг авах гэрээгээ хийчихсэн 70мвт-ыг бид нэг 10 сарын 1-ний хувьд орж ирэх болов гэж бодож байгаа. Тэгээд манай аукцион өнөөдрөөс маргааш нээгдэх учраас эхний ээлждээ бид зөв хэрэглээтэй явахад болчих болов уу гэсэн ийм төлөвтэй байгаа. Тэгэхдээ хүндрэлтэй. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд гишүүн асуулт асууна аа.

Л.Соронзонболд: Өнөөдөр эрчим хүчний салбарын танилцуулга хийж байгаа. Эрчим хүчний яамны хамт олондоо талархаж байна. Монгол Улсын эрчим хүчний үнэ тариф маань зүгээр 2 хөршийнхөө үнэ тарифтай харьцуулахад хэр зөрөөтэй байгаа юм бэ? Бид нар ингээд дотооддоо үйлдвэрлэж байна гээд нөгөө оптуниги косттойгоо харьцуулахад арай өндрөөр үйлдвэрлэдэг ийм хэлбэр лүү явж болохгүй шүү дээ тэ. Тэгэхээр өнөөдөр ингээд хараад үзэхээр дизель түлшний үнэ өсөж байна. Ингээд энийг дагаад уул уурхайн нүүрсний өртөг өснө. Ингээд манай үйлдвэрлэж байгаа эрчим хүчний цахилгааны маань үнэ өснө. Ингээд явахаар энэ өртөг маань явсаар байгаад нөгөө боломжит харьцуулж болох ёстой өртөгөөсөө хэтэрч болохгүй. Тэгэхээр нөгөө талаас саяын Найдалаа сайдын яриад байгаа зөвхөн үнэ тарифаас гадна тэр дотоод зардлаа хэмнэх талаар тийм энэ зардлыг өртгийг бууруулах талаар ямар шинэ санаачилгууд хийх гэж байна энэ тэр гээд ийм олон ажлууд төлөвлөх шаардлага байгаад байгаа юм.

Тэгээд энэ тал дээр ер нь ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ гэж 1 дүгээр асуулт байгаад байна.

Дараагаар нь ингээд хараад үзэхээр манай энэ аймгууд руу явж байгаа энэ дамжуулах шугам сүлжээний энэ элэгдэл энэ чанарын асуудал аягүй хүндрэлтэй

харагдаад байгаа юм. Ер нь Монгол Улсын хэмжээнд энэ дамжуулах шугам сүлжээний шинэчлэлийг хийхэд хэдэн төгрөгийн асуудал хэрэгтэй байгаад байгаа юм. Энийг та бүхэн ямар хугацаанд ер нь хөрөнгө оруулалтыг нь хийгээд энэ шинэчилж дуусгана гэж харж байгаа юм бэ гээд ийм 2 дугаар асуулт байна.

Гуравдугаарт энэ Эрчим хүчний яамнаас энэ эрчим хүчний шилжилтийн стратеги гэж гаргаж ирээд энэний бодлогын хүрээнд олон төрлийн нөөц ашиглаад олон эх үүсвэртэй ийм станцууд байгуулах гэж орж ирж байгаа нь маш зөв бодлого байна гэж харж байгаа. Гэхдээ 2041-ээс 2005 онд бол нүүрсний ДЦС-уудыг үе шаттайгаар зогсооно оо гээд энэ төлөвлөгөөнд орсон байна. Тэгэхээр энэ хэдэн хэдий ямар хэмжээний хүчин чадалтай хэчнээн станцуудыг зогсоогоод тэдгээрийгээ эргүүлээд ямар эх үүсвэртэй станцуудаар нөхөхөөр тооцоолж байгаа юм гэдэг ч юм уу. Иймэрхүү тооцооллууд нь мэдээж гарсан байдаг энэ талаар нэг тодруулъя гэж бодсон юм аа.

Д.Үүрийнтуяа: Индрийн микрофоныг өгье.

Э.Түвшинчулуун: Түвшинчулуун эрчим хүчний зохицуулах хороо Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Үнэ тарифын хувьд өртөг бол өнөөдрийн байдлаар 1квт цаг цахилгааны дундаж өртөг 333 төгрөг болсон байгаа. бид 280 төгрөгөөр дундаж үнээр зарж байгаа. өртөгт нь хүргэнэ гэх юм бол 18.9 хувь нэмж байж өртөгтөө хүрэхээр байж байгаа. Сая бид нар нэлээд 2024 оны нэмэлтээс хойш нэлээн судалгаа хийсэн. Олон улсын байгууллагуудаар судалгаа хийлгэсэн. Тэгээд аль болохоор хэрэглэгч дээр дарамт багатай байхаар энэ удаагийн тарифын өөрчлөлтийг хийгээд 5 хувь л нэмсэн байж байгаа. Юуны хувьд 2 хөрштэй харьцуулж үзэх юм бол бүгд найрамдах Хятад ард улсад бол айл өрхөд тариф бол 7.7 цент байна. ААНБ-ын тариф 11.6 цент байна. ОХУ-д бол айл өрхийнх 7.1 цент, ААНБ нь 10.7 цент. Монгол Улсынх бол айл өрхийнх нь 6 цент, ААНБ-д 8.7 цент байгаа. Яг өнөөдрийн байгаа ханш. Дээр нь нэмээд хэлчихэд энэ өртөг яагаад ингээд өсөөд байна вэ гэдэг дээр мэдээж өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа. Энэнээс гадна хамгийн гол нөлөөлөл юунд явж байна гэхээр яг сүүлийн үед бол нөгөө өндөр үнэтэй эх үүсвэрүүдийн нийлүүлэлт нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл одоогийн байдлаар манай хуучны станцууд 30 хувийг нь биш 70 хувийг нь хангаад шинэ Бөөрөлжүүт, Тосонцэнгэлийн станц, нар салхины станц нийлээд нэг 30 хувийг нь одоогийн эх үүсвэр бол хангаж байгаа юм. Энэ бол хэмжээ өөрчлөгдөөд 2029, 2030 он гэхэд бол 70 хувийг нь энэ хувийн хэвшлийн шинэ эх үүсвэрүүд хангаад 30 хувийг нь манай энэ хуучны ажиллаж байгаа 2, 3, 4 дүгээр цахилгаан станц Дархан Эрдэнэтийн станц хангахаар байж байгаа.

Тэгэхээр энэ бол өндөр үнэтэй нийлүүлэлт нэмэгдэж байгаа учраас өртөгт бол хамгийн гол нөлөө үзүүлээд байгаа асуудал энд байгаа. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Тодруулах уу Соронзонболд гишүүн ээ. Индрийн микрофон хариултыг минутдаа багтаагаад өгнө шүү. Тус тусдаа минут аваад нэмэлтээр нэг минут.

Ч.Амарсанаа: Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Эрчим хүчний яамны зүгээс бол 2026-2030 онд бол нийт 2365км ЦДАШ-ын төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2026 онд бол нийт 4 төслөөр 764км шугам хөрөнгө оруулалт нь бол 214 сая долларын ийм хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байгаа. Эдгээр төслүүд хэрэгжсэнээр бол уул уурхайн томоохон стратегийн хэрэглэгчид Өмнөговь, Дорноговь аймгийн хэрэглэгчид болон Улаанбаатар хот мөн бүсүүдийг холбосон томоохон магистрал ЦДАШ-ууд баригдана. Монгол Улсын гол хэрэглээ бол Улаанбаатар хот орчмын бүс нутагт байдаг. Энийг бол цахилгаан дамжуулах түгээх шугам бол нэлээн элэгдэлд орсон. Үйлдвэрлэж байгаа эрчим хүчийг яг бүр гол хэрэглээний бүс нутгууд руу дамжуулахад бас.

Д.Үүрийнтуяа: Гүйцээж хариулья.

Ч.Амарсанаа: Шугамуудын нэвтрүүлэх чадвар тулсан учраас 1 тэрбум ам.долларын төслийг хэрэгжүүлэхээр Дэлхийн банк, ЕСБХБ, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкттай хамтран ТЭЗҮ болон зураг төслийн ажлыг бас хэрэгжүүлээд явж байгаа. Төслийг бол 2 үе шаттайгаар 2032 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Д.Үүрийнтуяа: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тэгэхээр яах вэ эрчим хүчний зохицуулах хорооны саяын ингээд хариултыг харахаар манай өртөг маань ААН-д өгч байгаа маань 8.7 цент гэхээр өртөг чинь өөрөө бараг 9 цент хавьцаа болчихоод байна шүү дээ. Энэ чинь өөрөө юуг хэлээд байна вэ гэхээр бид нар ер нь бол 10-15 хувиар л үнээ өсгөнө. Тэгээд л бид нар 2 хөршийнхөө энэ үнийн түвшинд оччихож байгаа байхгүй юу. Тэгэнгүүт дотооддоо үйлдвэрлэж байгаа нь гээд бид нар ингээд харьцуулаад авах боломжтой хүнээс ийм өртгөөр өндөр хий үйлдвэрлээд байх шаардлагагүй байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Эрчим хүчний яам нь ч тэр алив зөвшөөрөл өгөхдөө энэ дээр нэлээн бодлогын анхаарахгүй бол зөвхөн өртгийг яаж бууруулах вэ гэдэг тал руу нь илүү менежментийн бодлогууд гаргаж хэрэгжүүлэхгүй бол ер нь болохгүй байна гэдэг нь харагдаж байна гэж бодож байна. Тэгэхээр энэ дээрээ анхаарах ёстой байх гэж хэлмээр санагдаад байгаа юм.

Тэгээд түрүүний тэр нөгөө нэг шилжилтийн стратеги дээр нэг ярьсан шүү дээ? Нүүрсний ДЦС буу хаах гэж байгаа гээд. Тэрний хариултыг авчих гээд. Тэрэн дээр тодорхой дүн байгаа юм уу. Тэр нүүрсний шилжилтийн стратеги, эрчим хүчний шилжилтийн стратеги дээр нүүрсний ДЦС-ыг.

Д.Үүрийнтуяа: Найдалаа сайдын микрофоныг өгье.

Б.Найдалаа: Маш товчхон хариулья аа. Шилжилтийн стратеги дээр юу байгаа вэ гэхээр одоогоос 2050 он хүртэл Монгол Улс эрчим хүчнийхээ эх үүсвэрийг юунаас авах вэ гэдгийг он оноор нь тов тодорхой заачихсан байгаа. Монгол Улс нүүрсээр баян. Тэгээд нүүрснээс татгалзана гэсэн үг биш. Зүгээр нүүрсний оролцох эрчим хүчний оруулж байгаа хувь нэмрийг оновчтой түвшинд аваачаад нүүрсээ өөр хэлбэрээр цэвэр байдлаар ашиглахыг хэлж байгаа юм аа.

Түүнээс нүүрснээс татгалзаад учир зүггүй өөр рүү шилжинэ гэсэн үг биш. Тэгээд нүүрсний хувь оролцоо багасна шууд утгаараа. Нөгөө талаасаа устөрөгч, хий, био масс, сэргээгдэх мөн цөмийн станцыг хөгжүүлнэ гэж явж байгаа юм аа.

Соронзонболд гишүүн түрүүн асуусан засаглалтай холбоотой яах аргагүй мөн өртгийг бууруулах ёстой. Өртгийг бууруулахын тулд бид нар 1 дүгээрт шууд утгаараа энэ дуудлага худалдан авагдсан онууд бол сэргээгдэхийн ялангуяа үнэ тарифыг буулгах бодлого юм байгаа юм.

Нөгөө талаасаа засаглалын тэр үр ашиг зардлыг бууруулах тэр үнэхээр чухал. Бид нар хамгийн багаар үйлдвэрлэж чадаж байгаа юм уу гээд энийг бууруулахын тулд.

Д.Үүрийнтуяа: Гүйцээж хариулъя.

Б.Найдалаа: Тухайлбал Эрчим хүчний яам 27 ТӨК-ийг ер нь удирдаж байна гэсэн үг. Тэгсэн хэрнээ засаглалыг хариуцдаг нэгжгүй байсан. Одоо бид нар бүтцийн өөрчлөлт хийгээд саналаа оруулсан байгаа. Засаглалыг хариуцдаг 1 нэгжтэй болмоор байгаа юм аа.

Хоёрдугаарт энэ Засгийн газрын түвшинд ярьж байгаа ТӨК-удын засаглалыг сайжруулах хүрээнд энэ компаниудыг багцлаад олон улсын бирж дээр хөрөнгө босгоод тэрүүгээрээ менежментийг нь сайжруулах ийм төсөл бас нийт зөвхөн эрчим хүч гэлтгүйгээр явж байгаа. Бас нэг чухал зүйл дээр ухаалаг гээд байгаа нь энэ юм байгаа юм.

Хүн очих шаардлагагүйгээр хүнээс хамааралгүйгээр тэр системийг хийх юм зардал буурах юм аа. Тэгээд эцсийн дүндээ би зүгээр эцэст нь хэлэхэд Монгол Улсын эрчим хүчний систем өөрийн өртгөө нөхчихдөг. Хэт өндөр үнэтэй биш. Тэгэхдээ яг ингээд өрсөлдөх чадвартай 2 улсынхаа түвшинтэй ойролцоодуу ийм зах зээлийн ханш тогтож байж энэ салбарын хөгжил эдийн засгийн тулгуур болох юм аа. Тэгэхээр ойролцоогоор бол тэр үнийн.

Д.Үүрийнтуяа: Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Эрчим хүчний яамныхан бас санаачилгатай мэдээллээ хүргэж байгаад баярлалаа. 4 асуулт байна. Эхнийх нь 5 байршилд сэргээгдэх эрчим хүчний станц барина гээд хувийн хэвшлүүдээс санал авч байгаа. Нууц биш бол хэдэн компаниас санал ирсэн бэ? Төр өөрөө бодлогоо тодорхой гаргаад манайх хэрэгжүүлнэ гээд хэлэх юм бол манай ААН-үүд бүгдээрээ бизнесээ өргөтгөх үүднээс эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс бол дэмжээд ажиллах бүрэн боломж байгаа гэж харж байгаа. Бага үнийн саналаар шалгаруулна гэсэн байна. Эрчим хүчний яамны зүгээс 1квт цагийг хэдэн төгрөгөөр тооцож байгаа вэ?

Хоёрдугаар асуулт доголдол гарсан тохиолдолд 290мвт чадал хязгаарлана гэсэн байна аа? Сая хэлсэн эхний ээлжид 25 мянга дараа нь 80 мянган өрхийг ингээд хязгаарлаад явна гэж байгаа. Энийгээ яг аль байршил дээр хаана хэдэн цагт тасрах юм бэ гэсэн тийм төлөвлөгөө байна уу? Тэгэхээр зөвхөн өрхийн тоогоор тэгж харагдаад байхлаар, ААН-ийн тоогоор харагдаад байхаар манайх тасрах юм уу үгүй юм уу гэдэг нь мэдэгдэхгүй байгаа. Тэгэхлээр яг доголдол гарах юм бол энэ энэ байршлууд дээр дүүрэг, хороо, аймаг сумаар нь хязгаарлана гэсэн төлөвлөгөө байх ёстой. УСУГ халуун ус тасарна гэдэг мэдээллийг их тодорхой өгдөг болоод байгаа шүү дээ сүүлийн хэдэн жил. Тэдээс тэдний өдрүүдэд тасална гээд л. Яг ирэх өдөр ирдэг болж байгаа. Эрчим хүчний яам ч гэсэн энэ хэмжээнд ажиллах хэрэгтэй. Тэр

мэдээлэл байна уу? 3 дугаар асуулт. Ахуйн хэрэглээн дэх нүүрсэн халаалтыг үе шаттай бууруулна гээд та бүхний тараасан материал дээр байна л даа. Тэгээд 1 бодлого, 9 ажил, 3 зарчим гэж байна. Энийг дэмжиж байна. Гэхдээ энэ дотор нэг зүйл тусаагүй байна. Эрчим хүчний хэмнэлтийг ерөөсөө бичээгүй байна. Эрчим хүчний зохицуулах хороон дээр өнөөдөр Барилгын эрчим хүчний аудитор гэж бэлтгэж байгаа. Үйлдвэрлэлийн болон бусад зүйлүүд 3 төрлөөр байгаа. Барилгын эрчим хүчний аудиторынхоо тоог бид нар нэмэгдүүлэхгүй бол эх үүсвэрээ нэмэгдүүлнэ л гэж яриад байдаг. Түүнээс биш хэмнэлтээ ерөөсөө ярьж чадахгүй байгаад байгаа.

Энэ дээр одоо 2026 оны байдлаар хэдэн аудитор байна вэ? Барилгын эрчим хүчний аудитор. Цаашдаа энэ тоог хэд болгож нэмэгдүүлэх гэж байгаа төлөвлөгөө байна уу? Төсөөлөл байна уу?

Дөрөвдүгээр асуулт. 5 жилийн үндсэн чиглэл дээр та бүхний зорилго зорилтууд 13 туссан байгаа. Суурь түвшин 2024 оноор, зорилтот түвшин 2026, 2027, 2028, 2030 он хүртэл явж байгаа. Сая жишээлбэл экспорт хэд хэзээ экспорт эрчим хүчийг экспортолж чадах вэ гэдэг асуултын хариулт тэрэн дээр байгаа шүү дээ. Та бүхэн тэрнээсээ харах юм бол шууд хэлэх боломжтой тоо. Өнгөрсөн жил баталсан Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол байгаа. Очирбат гишүүнтэй 100 хүнд оролцоод ажлын хэсгээр нь батлуулсан. 10 мянган нарны дээвэр гээд хөтөлбөрийг хийсэн тусгасан байгаа. Айлууд нарны панел тавиад илүүдэл цахилгаанаа төвийн сүлжээнд нийлүүлэх боломжтой байгаа. Гэхдээ энэ нь дэд станцаасаа хамаараад боломжтой боломжгүй хороодууд багуудын байршлууд байгаа. Тэр байршлуудыг тодорхойлсон бичиг баримт байна уу. Яг аль дүүргийн аль хороон дээр төрөөс төвийн сүлжээнд цахилгаан авах боломжтой юм бэ гэсэн энэ 4 асуултад хариулт авъя аа.

Д.Үүрийнтуяа: Найдалаа сайдын микрофоныг өгье.

Б.Найдалаа: Би товч суурийг нь тавиад манайхан энэ тов тодорхой хариулчихна аа. Энэ бол бүгдээрээ тодорхой тоотой, судалгаатай, хугацаатай байдаг. Энэ салбарын угаасаа үндсэн ажил нь энэ юм аа. Саяын тэр 5 аймгийн нээлттэй сонгон шалгаруулалт дээр Монгол Улсад анх удаа болж байгаа гогцоо нээлттэй явж байгаа бүх юм Эрчим хүчний яамны веб сайт дээр байгаа. Дуудлага худалдаа нь бүр лайваар олон нийтэд ил тод явна. Нийт 115 компани сонирхлоо илэрхийлсэн, хөрөнгө оруулаад 12 сараас өмнө тэр төслийг хэрэгжүүлье гээд. Үүнээс албан ёсоор саналаа ирүүлээд шаардлага хангасан нь 19 компани үлдсэн. 19 компани 5 байршил дээр нөгөөдөр 4 дэх өдөр өрсөлдөнө өө гэсэн үг. Тэгээд энэнтэй холбоотой бүх мэдээлэл ил тод байгаа. Лайваар явах учир энэ дээр та бүхэн үзээрэй. Үнэ өртгийн хувьд энийг хамгийн сонирхолтой зүйл энэ байгаа. Үнэ өртгийг Эрчим хүчний яам тогтоохгүй. Тэр байтугай нээлттэй сонгон шалгаруулалтын эрчим хүчний зохицуулах хороо ч тогтоохгүй энэ бол яг тэр төсөл хэрэгжиж байгаа бизнесийн зардал, өртөг, хөрөнгө оруулалтын зардал дээр гарахаас өөр ямар ч аргагүй. Энэ бол бид нарын бүгдээрээ ажиглах хэрэгтэй.

Монгол Улсын эрчим хүчний бодит үнэ гарна. Бодит үнэ энэнээс доошоо байх юм бол хэн ч хийхгүй үргэлж мөн эрчим хүчнийг хязгаарлана аа. Тэгэхээр яг энэ бол эрчим хүчний салбарын ялангуяа сэргээгдэх эрчим хүчний бодит үнэ гарах юм аа. Тэр хязгаарлалттай холбоотой төлөвлөгөөн дээр Цэрэнжамц дарга хариулна. Хэмнэлттэй холбоотой төлөвлөгөөнд Эрчим хүчний зохицуулах хорооноос

хариулна. Экспорттой холбоотой асуудал 10 мянган айлын орон сууц Нарны юун дээр Энхтүвшин дарга хариулна. Хэмнэлтийн хувьд бид нар энэ 9 ажилдаа яг нэрлэж оруулаагүй боловч том ажлын нэг. Тухайлбал энэ өвлийн ачааллыг давахын тулд бид хэрэглээгээ бас нөгөө талаасаа зөвхөн үйлдвэрлэлд бэлэн цахилгаан дулаан хүлээх биш хэрэглээгээ иргэд бид нар өөрсдөө хэмнэдэг тохируулдаг байх ёстой юм аа. Энэ талаар мэдээллийн сурталчилгааны ухуулгын ийм ажлыг бид нар өргөн хэлэлцүүлгийг өрнүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Индрийн микрофоныг хүн тус бүрээр 2 минутаар өгье.

С.Цэрэнжамц: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбар үндсэндээ 5 сарын 10, 9 сарын 10-нд өвөл зуны гэсэн 2 горим баталдаг. Тэгэхээр 9 сарын 10-нд гарах өвлийн горимоор бол 24 багц болгочихсон байгаа хамгийн 530мвт-ын дээр. Тэгэхээр тэр байршлууд нь нэг бүрчлэн гараад төлөвлөгөө нь гарчихдаг. Зуны бага ачааллын горим дээр манайх энэ сая Ус суваг гэж яриад байгаа тэр чинь манай эрчим хүчний салбарын зуны горимд батлагдаж байгаа. Горимын дагуу бид шугам сүлжээгээ засварлахад хийж зориулдаг ийм л горим байгаа юм. Тэгэхээр бүх төлөвлөгөөнүүд бүх юм гараад явчихна. Гэхдээ аль болох хязгаарлалтыг хийхгүй гэж байна. Тэгэхдээ одоо гэмтэл саатлууд их гардаг. Яагаад гэхээр хэрэглээ, үйлдвэрлэл 2 хамтран явдаг учраас манай салбарын онцлог энэ дээр байдаг юм шүү. Та бүхэнд баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Дараагийн хариултыг. Индрийн микрофон өгье.

Ө.Түвшинчулуун: Эрчим хүчний зохицуулах хороо Түвшинчулуун хариулж байна. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тэгээд үнэхээрийн эрчим хүчний хэмнэлтийн асуудал хамгийн чухал байгаа. Энэ эрчим хүчний дутагдалтай энэ үед эрчим хүчийг үнэхээрийн хэмнэж чадах юм бол бараг дахиад нэг дунд оврын шинэ эх үүсвэр барих түвшний ийм хэмнэлтийг эх үүсвэрийг бүрдүүлж ийм боломжтой байгаа. Өнөөдрийн байдлаар цахилгаан дулааны эрчим хүчний хэмнэлтийн 83 аудитор байна. Яг барилгын хэмнэлтийн 35 аудитор яг эрхээ аваад ажиллаж байгаа. Ер нь энэ 35 аудиторуудын хувьд бол барилгын эрчим хүч барилгын их эрчим хүчний хэмнэлт дээр бол зөвлөмж гаргаад ингээд ажиллаж байгаа. Хариулт дууслаа.

Г.Энхтүвшин: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамны бодлогын газрын дарга Энхтүвшин.

Хэрэглэгчийн бага оврын сэргээгдэх эрчим хүчний тухайд бол Улаанбаатар хотын хэмжээнд 53.4мвт-ын нарны хавтан бол 102 фидерт холбох боломжтой байгаа. Байршлаар нь бол тооцоо судалгаа хийчихсэн байгаа. Тухайлбал 35 киловаттын дэд станцад холбогдох тооцоог хийсэн. Тухайлбал Санзай, Хуурай мухар, Ар гүнт, Өөвөр гүнт, Зүүн салаа, Баруун салаа гэх мэтчилэн ингээд байршлуудыг тодорхой гаргасан байгаа. Эрчим хүчний экспортын хувьд бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 5 жилийн үндсэн чиглэл дээр бол эрчим хүчний экспортыг бол эхлүүлнэ гэж дурдсан байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтыг бол татах замаар эхлүүлнэ. Хариуцах нь бол Шадар сайдын ажлын алба, Эрчим хүчний яам бол хамтран хэрэгжүүлэгчээр ингээд орохоор тусгагдсан байгаа. Хариулж дууслаа.

Д.Үүрийнтуяа: Тодруулъя Лувсанжамц гишүүний микрофоныг өгье.

Г.Лувсанжамц: Маш тодорхой хариуллаа. Баярлалаа. Тэгээд эрчим хүчний аудитор дээр цаашдаа хэд болгох вэ гэсэн төлөвлөгөөг асуусан тэрийг мэдмээр байна. Яагаад гэхлээр өнгөрсөн жил 35 аудитортой байсан. Энэ жил хэвээрээ л байна. Сая яг хэмнэлтээ бид нар хэрэгжүүлээд л явах юм бол цаашдаа бид нар дор хаяж жилдээ 200-аас 300 аудиторууд маань 5-аас 10 барилга дээр эрчим хүчний аудит хийгээд тэрнийгээ дулаалдаг, утаа гаргадаггүй болгодог, яндангүй болгодог гэсэн ажлууд хийгээд явах хэрэгтэй байгаа. Тэгэхлээр байгаа 35 цаашдаа хэд болж нэмэгдэх вэ гэсэн нэг тодруулга асуулт байна.

Хоёр дахь нь өнгөрсөн жилийн Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол, 119 дүгээр тогтоол 2 байгаа. Энэ бол асуулт гэхээсээ илүүтэй энэ дээр маш олон та бүхний хийх ажил дээр тусах боломжтой дэмжигдэх боломжтой саналууд байгаа учраас тэрийг 9 ажил дээрээ хийж өгөөсэй гэж санал хэлмээр байна.

Д.Үүрийнтуяа: Хариулъя индерийн микрофоныг өгье.

Ө.Түвшинчулуун: Тийм гишүүнтэй Эрчим хүчний зохицуулах хороо санал нэг байгаа. Бид 35 аудитор бэлдээд жил болгон ажлыг нь дүгнээд юу яадаг ачааллыг нь авч үздэг. Сүүлийн үед энэ 2024 оны үнэ тарифын өөрчлөлтөөс хойш ер нь энэ орон байраа дулаалъя гэдэг нэг томоохон ийм аян өрнөж явж байгаа. Энэ дээр эрчим хүчний энэ хэмнэлтийн барилгын хэмнэлтийн чиглэлээр бол нэлээд их ажлууд гарч ирж байгаа. Бид бол энэ 35 аудиторыг нэг дахин ер нь дал болгож нэмэхэд ер нь боломжтой юм байна гэсэн тооцооллыг манай хүмүүс хийчихсэн байгаа.

Д.Үүрийнтуяа: Лувсанжамц гишүүнд тодруулах нэг минут өгье.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Тэгвэл та бүхэн маань сая хэлж байгаа нэг бодлого 9 ажил, 3 зарчим дээрээ бас энэ эхний драфт эхний хувилбар юм байна шүү дээ тиймээ. Энийгээ дахиад дэлгэрүүлж бичиж тусгах гэж би ойлголоо. Тэр зүйлийг нь Эдийн засгийн байнгын хороон дээрээ мэдээлэл авъя.

Хоёрдугаарт нь жил бүрийн 5 сарын 10, 9 сарын 10-нд хязгаарлах горим баталдаг гэж байгаа. Энэ хязгаарлах горим батлахаараа энэ мэдээллээ олон нийтэд түгээх ажлыг сайн хийвэл зүгээр гэж бодож байна. Одоо энэ ус таслах хуваарийг бол бараг л хотоороо мэддэг болчихлоо шүү дээ тиймээ. Манай хотхон манай хороо, манай дүүрэг хэзээ тасрах юм байна гэдгийг мэддэгтэй адилхан сая хэлсэн таны дэлгэрэнгүй хэлсэн байршлуудыгаа бид нар өвөл болохоос өмнө эсвэл дулаан өгөх үедээ 290мвт дутах юм бол эндээс эхэлж хязгаарлана шүү гэсэн бодит мэдээллийг өгөх буюу төр өөрөө тодорхой байдлыг бий болгох ёстой. Энэ дээр нь та бүхэн маань анхаарч ажиллахыг хүсье ээ. Амжилт хүсье.

Д.Үүрийнтуяа: Гишүүн санал хэллээ. Батчимэг гишүүн асуултаа асууя.

П.Батчимэг: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Өнөөдөр Эрчим хүчний яамнаас сайд, түүний аппарат өргөн бүрэлдэхүүнээр ирж Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд мэдээлэл хийсэн. Мэдээллээр дамжуулан салбарын зовлон их ярьж байна л даа. Ер нь бол энэ Эрчим хүчний яам яасан ч үйл лайтай юм. Үг

хэллэгтэй яам юм бэ дээ. Танай яаманд ер нь гэгээнтэн очоод ч суут ухаантан очоод ч шилдэг Монгол Улсын инженер, мэргэжилтэн, менежер очоод ч ер нь энэ яамны үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт энэ алдагдал, энэ эрсдэл, энэ авлигал, энэ хулгай ер нь зогсох уу? Би итгэхгүй байна. Хэнбугай ямар сайд ч Засгийн газар солигдох бүрд томилогдоод очдог. Доогуур байж байгаа тэр дунд шатны алба албан тушаалтнуудын авлигал, хулгай олон нийтийн хэлдгээр цавчаа энийг зогсоохгүйгээр Эрчим хүчний яамны хөгжил ирээдүй хэзээ ч харагдахгүй. Тэр доор байгаа зэрлэг өвс, тэр доор байгаа тэр хогийн ургамлыг тастаагүй цагт Эрчим хүчний яамны энэ алдагдал дутагдал, энэ санхүүгийн, энэ болохгүй бүтэхгүй бүх юм хэв хэвээрээ л байна.

Өнөөдөр ингээд 738.6 тэрбум төгрөгийн алдагдалтай 2024 оны үнийн тариф индексжүүлэлтийг хойшлуулснаас болж ийм ийм 200 хэдэн тэрбумаар ингэж алдангид орсон, одоо ингээд одоо бид нар ерөөсөө цаашаа явах аргагүй боллоо гээд ингээд энэ юун дээр гараад ирсэн. Гэтэл өнөөдөр тэрийгээ нөхөх гээд, шархаа нөхөх гээд иргэд, ААН-ийн карма руу дайраад эхэлчихсэн. Сая энэ өнгөрсөн 6 дугаар сарын 5-нд Улсын Их Хурал дээр баахан татварын хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн хөнгөлөлт яах вэ, ийх вэ, татвараа яах вэ, яаж ямар шийдэл гарах вэ гээд хуралдаж байхад энэ хойгуур л ерөөсөө шууд Эрчим хүчний зохицуулах хороо хуралдаад л 5 хувиар нэмээд хаячихсан. Одоо намар дахиад энүүгээрээ 236 тэрбумаа олчихно гэж байгаа юм. Бүүр ичихгүй энд биччихсэн байгаа шүү дээ. Тэгээд дараа нь намар дахиад нэмэх гэж байна. Нөгөө 18.8 хувийн нөгөө нэмэх нэмэгдэл дээрээ хүрэх юм байна л даа. Ингэж нөгөө хүмүүсийг бухимдуулах энэ нөгөө уур цахилгааныг нь хаачихсан үед чимээгүй сэмээрхэн ингээд хулгайгаар нэг сая нэмчихсэн байгаа юм. Ямар ч иргэд, ААН ямар ч мэдээлэлгүй сууж байгаа байхгүй юу.

Намар дахиад нэмнэ, бүр ингээд шаталж үечилж нэмнэ гээд бүр энд биччихсэн.

Д.Үүрийнтуяа: Нэг минут нэмж өгье гишүүнд.

П.Батчимэг: Намар 9 сард дахиад хэдийг нэмэх гэж байна. Эрчим хүчний зохицуулах хорооны даргаас асууя. Та төвлөрсөн дулаан 50м² орон сууцад амьдардаг, 4 ам бүлтэй дундаж хэрэглээтэй айлын цахилгааны сарын хэрэглээ, дулааны сарын хэрэглээг хэлээд жилээр нь тооцоод надаа нэг хариулаад өгөөрэй. Ер нь Эрчим хүчний яам энэ олон бараг 1.1 их наяд шахам саяын энэ юуны хэрэгцээ шаардлага байж байгаа энэ төсөв хэзээ яаж тэрийгээ нөхөж олох юм. Ямар хугацаанд юугаар, өвөлжилтийн бэлтгэл 2 хувиар мөн урд оныхоо мөн үеийнхтэй харьцуулахад 2 хувиар бага явж байна гэж байна.

Тэгэхээр өвөлжилтийн тухай бид юу ойлгож суух юм бэ?

Д.Үүрийнтуяа: Хариулт аваад нэмж тодруулж болно гишүүн.

Хэн хариулах вэ? Индрийн микрофон.

Ө.Түвшинчулуун: Эрчим хүчний зохицуулах хороо Түвшинчулуун Батчимэг гишүүний асуултад хариулъя аа. Ер нь бол эрчим хүчний салбар санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаа. Мэдээж энэ дээр бол олон хүчин зүйл нөлөөлж байгаа. Олон жил энэ үнэ тарифыг хөдөлгөж чадахгүй үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгөөс нь

бага үнээр өгөөд байхаар энэ салбар өөрөө алдагдалд ороод байгаа. Тэгээд бид бол сүүлийн нэмэлтээр бол сая 5 хувь нэмсэн гэж та хэлсэн. Тэгээд энэ дээр би сая гишүүний асуусан бид дундаж айл гэж авч үзэж байгаа. Мэдээж айл болгоны хэрэглээ өөр өөр. 4 ам бүлтэй 50м² талбайтай ийм айл дулаан сард 42108 төгрөг төлж байгаа юм. Сард дулаан нь. Жилд бол 410459 төгрөг төлж байгаа. Одоо ийм 4 ам бүлтэй, 50м² талбайтай ийм айл. Цахилгааны хувьд бол сард саяын нэмэгдсэн үнээр бол 52 мянган төгрөг сард гарч байгаа.

Ингээд нийлээд бол нэг 92 мянган төгрөгийг цахилгаан дулаандаа бол ингэж төлж байгаа.

Дулааны үнийн хувьд бол 2019 оноос хойш дулааны үнэ тарифт бол өөрчлөлт ороогүй ээ. Ороогүй байж байгаа.

2024 оны өөрчлөлт бол хойшлоод тэгээд сая 5 хувь л гэж өөрчлөгдөж байгаа. Мэдээж бид аль болохоор мэдээж айл өрхөд ААНБ-даа аль болох бас дарамт бага байх байдлаар л тооцооллоо хийж ингэж бага багаар ингэж үе шаттайгаар нэмье гэдэг ийм хувилбарыг сонгож байгаа.

2024 онд бол та бүхэн мэдэж байгаа цахилгааныг бол дунджаар 30 хувь гэсэн боловч ААНБ-ыг 30 хувь, уул уурхайг 15 хувь, айл өрхийг бол 45-аас бараг 85 хувиар нэмж байсан. Энэ удаадаа бол бид бол тийм огцом нэмэлт хийхгүй гэсэн ийм байр суурьтай байгаа. Яах вэ мэдээллийн хувьд бол яах вэ Зохицуулах хороо бид өөрсдийнхөө хэмжээнд мэдээллийг бол явуулж байгаа. Тэгээд тэр болгон нийтэд сайн хүрэхгүй байж бас магадгүй. Тэгэхдээ бид үнэ тарифыг нэмэхэд бол Захиргааны ерөнхий хуулийн дагуу процесс явагдаж байгаа. Эхлээд сар мэдээллийг веб сайт дээр тавиад саналууд авч байгаа. Тэгээд тарифтай зохицуулах хороо тогтоол гарсны дараа Хууль зүйн яаманд бүртгүүлж байгаа. Ингэсний дараа нөгөөдөх өнөө Төрийн мэдээлэл сэтгүүл дээр гарсан өдрөөсөө хүчин төгөлдөр ийм процессоор л яалгдаж байгаа.

Д.Үүрийнтуяа: Гишүүн тодруулъя. Батчимэг гишүүнд тодруулах минут өгье.

П.Батчимэг: Та миний хийсэн тооцооллоос таны хийсэн тооцоолол буруу байна. 410 мянган төгрөг хэзээ ч сард төлөхгүй л дээ. Дулаан цахилгаандаа жилдээ, жилдээ. Жилдээ төлөхгүй, ямар ч боломжгүй. Цахилгаан 50 мянгаас 80 мянга, дулаан нь 40 мянгаас 70 мянгын хооронд. Тэгэхээр ер нь бол та нэг дахин, нэг хувь, нэг дахин бага үнэ хэлж байна. Ер нь 800-аас 900 мянган төгрөгийг тогтмол төлж байгаа. Та магадгүй уулын юунд лаа бариад том бүдүүн мод Швейцарын баячууд шиг амьдардаг бол яг тиймэрхүү байж магадгүй. Энэ 236.6 тэрбум төгрөг энэ 5 хувиар нэмэхэд айл өрх ААН-ийн цахилгаан дулааныг 5 хувиар нэмэхэд 236.6 тэрбум төгрөгийг нэмэлт орлогын эх үүсвэр ингэж орж ирнэ гэж байна.

Д.Үүрийнтуяа: Найдалаа сайд хариулъя. Найдалаа сайдын микрофоныг өгье.

Б.Найдалаа: Батчимэг гишүүний асуултад хариулъя.

Эрчим хүчний салбар үнэхээр хүнд асуудал байгаа, урт болон богино хугацааны ужгирсан асуудал байна. Энэ асуудалд та санаа зовж байгаа юм байна. Би санал нэгтэй байна. Үнэхээр баярлаж байна. Энэ салбар асуудлаасаа гарна. 18

мянган хүн ажиллаж байгаа. Олон 10 жилийн түүхтэй. Ямар ч асуудалгүй. Тэр хулгай зэлгий цавчааг үгүй хийнэ. Асуудал байхгүй, шийдэл нь тодорхой. Энэ дээр та битгий эргэлзээрэй. Би зүгээр гишүүдээсээ хүсэх ганцхан л зүйл байна. Бодлогын хувьд дэмжээд өгөөсэй гэж байна. Эрчим хүчний салбарыг халамжийн салбар биш болгомоор байна. Эрчим хүчний салбар яахаараа эрчим хүчээ үйлдвэрлэхдээ биш хөнгөлөлт халамжийн яам шиг ажиллах ёстой билээ. Энийг бол яг бодлогын хувьд салгаж өгөхийг хүсэж байна. Эрчим хүчний салбарын багцад халамжийн маягтай үнэ төлбөрөөр нь дамжуулж, тэгсэн хэрнээ алдагдлыг хиймлээр үүсгэдэг энэ үйл явдлыг таслан зогсоохыг би танаас болон гишүүдээс.

Д.Үүрийнтуяа: Тодруулгын цаг дууссан байна. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Миний бие бас өөрийн байр суурийг илэрхийлье. Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос эрхлэх асуудлын хүрээнд эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлыг эрчим хүчний сайдын мэдээллээр сонсох ийм хүсэлт албан бичгийг хүргүүлсэн. Эрчим хүчний салбар бол яалт ч үгүй Монгол Улсын үндэсний аюулгүй байдал бие даасан байдлыг хангах ёстой стратегийн ач холбогдол бүхий ийм хөгжлийн тэргүүлэх салбар. Гэхдээ өнөөдөр бол салбарын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлын өсөлт нь эрчим хүчний хэрэглээнийхээ өсөлтийг хангаж чадахгүйгээс болоод эрчим хүчний хязгаарлалт хийх эх үүсвэр дутагдах. Энэ асуудлууд өнгөрсөн өвөл бидэнд тохиолдсон.

Ийм ч учраас салбарын өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлын талаарх мэдээлэл мөн салбарын хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах учирч болзошгүй энэ эрсдэлээс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны ялангуяа ирэх өвлийн энэ оргил ачааллын үед эрсдэл тулгарсан үед ямар сөрөн гарах арга хэмжээ, даван туулах арга хэмжээний шуурхай төлөвлөгөө байна вэ. Энэ талаараа саналууд бэлтгэж танилцуулаач гэж ингэж бичиг явуулсан Байнгын хорооноос. Тэгээд өнөөдрийн танилцуулгад бол яг эрсдэлийг даван туулах чиглэлийн арга хэмжээний богино хугацаанд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний санал санаачилгууд харьцангуй бага орж ирсэн байна. Урт хугацааны бодлогын асуудлууд танилцуулагдаж орж иржээ.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэхдээ хэллээ. Очирбат гишүүн, Уянгаа гишүүн, Лувсанжамц гишүүн мөн Батчимэг гишүүн үүсээд байгаа нөхцөл байдлууд тулгамдсан асуудлуудтай тодорхой асуудлууд ярилаа.

Мөн Улсын Их Хурлын дарга Бямбацогт даргын хувьд тодорхой үүрэг чиглэлийг сая өглөө.

Улсын Их Хурлын тогтоол гаргая. Энэ тогтоолын төсөл дээр ажиллая гэж. Гэхдээ нэг зүйлийг онцолж хэлэх нь зүйтэй байна. Өнөөдөр эрчим хүчний салбар өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглаж энэ өвөлжилтийг даван өвөлжилтийг ямар нэгэн эрсдэлгүйгээр даван туулах өвөлжилтийн бэлтгэл ажлынхаа төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахад онцгой анхаарах ёстой болохоос биш Улсын Их Хурал хэрэглэгч дээр ачаалал үүрүүлсэн, үнэ тариф нэмэх тухай асуудлаар тогтоол гарахгүй ээ. Энийг онцгой анхаараарай.

Дотоодоосоо бид үр ашигтай, бүтээмжтэй, өгөөжтэй ажиллах энэ боломжуудаа салбарын хувьд эрэлхийлэх ёстой. Очирбат гишүүний хэлж байгаа

зөв л дөө энэ хэрэгжилт чинь 2 хувиар тасарчихсан явж байгаа юм биш үү гэж. Энэ алдаад байгаа асуудлуудаа нөхөх цаг хугацааны хувьд нөхөх, өртөг зардлаа бууруулах, үр ашгаа нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн ашиглалтын коэффициентийг нэмэгдүүлэх энэ чиглэлийнхээ асуудлыг та бүхэн шуурхай авч хэрэгжүүлэх энэ ажлуудаа оруулж ир ээ.

Үүнд бол Улсын Их Хурал, Байнгын хорооны зүгээс асуудлуудыг боловсруулж Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлье.

Хууль эрх зүйн өөрчлөлт дээр Улсын Их Хурал дэмжиж ажиллая. Харин хэрэглэгчдийн нуруун дээр үнэ тариф нэмдэг салбарын бүтцийн, салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэх менежментийн өөрчлөлтийг хийхгүйгээр зөвхөн үнэ тарифын өөрчлөлт хийдэг зүйлийг бол дэмжихгүй гэдгийг албан ёсоор хэлэх нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Тийм учраас Улсын Их Хурлын тогтоолын төсөл Байнгын хорооноос бэлтгэж хэлэлцүүлэх ажлыг Байнгын хороо зохион байгуулъя, 1 дүгээрт.

Хоёрдугаарт та бүхэн саяын Эрчим хүчний сайдын танилцуулсан нэг бодлого, 3 зарчим, 9 ажил дээр Лувсанжамц гишүүний хэлсэн дэлгэрэнгүй мэдээллийг Байнгын хороонд болон Улсын Их Хурлын гишүүнд албан ёсоор хүргүүлээрэй гэдгийг хэлье ээ.

Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй холбоотой гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Эрчим хүчний сайдын мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт талархлаа илэрхийлье ээ.

17.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА